

## НЭГ. ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ

**Х**өдөөгийн хөгжлийн асуудал нь Монгол улсын хөгжлийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Энэ илтгэлд хөдөөгийн хөгжил гэдгийг өргөн хүрээгээр нь биш хөдөө аж ахуйн салбарын хөгжилтэй уялдуулан харуулахыг хичээв.

Саяхан болтол хөдөөгийн хөгжил гэхээсээ хөдөө аж ахуйн хөгжлийн тухай өөрөөр хэлбэл, салбарын хувьд эхний ээлжинд авч үзэж байв. Мал аж ахуй, газар тариалан гээд ХАА-н гол салбар нь хөдөөгийн хөгжлийн нэг гол тулгуур хүч мөн боловч хөдөөгийн хүн ам, эрүүл мэнд, боловсрол, байгаль орчин, дэд бүтэц зэрэг харилцан уялдаатай олон асуудлыг цогцоор авч үзэж хөдөөгийн хөгжлийн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх ёстой. Өөрөөр хэлбэл, хүн төвтэй хөгжлийн бодлого гэсэн үг.

Төр засгийн зүгээс сүүлийн жилүүдэд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, мянганы зам, эрчим хүчний хөтөлбөр, төрөөс хүнс хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого зэрэг улс орны эдийн засгийн хөгжлийн томоохон суурь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа боловч тэдгээрийн хэрэгжилт үр дүн нь төдийлөн хангалттай биш. Ялангуяа хөдөөгийн хүн ам тав тухтай, тогтвортой суурьшилтай ажиллаж амьдрах нөхцөл төдий л сайн бүрдэж чадахгүй, хөдөөд хөгжил хоцрогдонгуй байгаагаас хот хөдөөгийн ялгарал жил ирэх тутам ихсэж ядуурал нэмэгдсээр байна.

1990-ээд оны эхээр улс орны хэмжээгээр зах зээлд шилжих процесст эрчимтэй явагдаж эхэлсэнтэй зэрэгцэн мал бараг зуун хувь хувьчлагдаж, тариалангийн улсын аж



ахуйнууд задарч, газар тариалан мөн “Хувийн хэвшлийн” болсон нь нийгэм эдийн засгийн шинэчлэлийн дагуу явагдсан зүй ёсны нааштай алхам байсан боловч зөвхөн мал, тариа хувьд очиж, хөдөөд зах зээлийн орчныг бүрдүүлэх бодлого зэрэгцэн хийгдээгүйгээс өмнөх тогтолцооны үед хөдөөд бий болсон асар их хөрөнгө, материал, техникийн бааз үрэгдэж, сүйрсэн сөрөг үр дагаварыг авчирсан юм. Эдийн засгийн 5 бүсүүд хоорондоо, бүс дотроо аймгуудын хооронд нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн, хүн амын боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ, дэд бүтцийн хангамж зэргээрээ ихээхэн ялгаатай байна.

Шинжлэх ухааны академийн үндэсний хөгжлийн хүрээлэнгээс хийсэн судалгаанаас үзэхэд нэг хүнд ногдох ДНБ Улаанбаатар хотод Дархан, Завхан аймгийн энэ үзүүлэлтээс 2.5-3 дахин их байна. Баруун бүсийнх нэг хүнд ногдох ДНБ Улаанбаатар хотын энэ үзүүлэлтээс 2.5 дахин бага, улсын дунджаас 1.7 дахин бага байна. Зүүн бүсийн нэг хүнд ногдох ДНБ баруун бүсийн энэ үзүүлэлтээс 23 хувиар бага байна. Мөн хүрээлэнгээс өөр нэг сонирхолтой судалгаа хийжээ. Энэ нь бүсүүдийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн төвшний нэгдсэн үнэлгээ юм. Энэ үнэлгээнээс үзэхэд Баян-Өлгий, Завхан, Говь-Алтай, Увс, Ховд аймгийн хөгжлийн ерөнхий төвшин Улаанбаатар хот, Орхон аймгийн энэ үзүүлэлтээс 9 дахин, Төв, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийнхаас 3-4 дахин доогуур байна.

Булган, Дундговь, Дархан аймгийн хөгжлийн ерөнхий төвшин баруун бүсийн 5 аймгийнхаас 2 дахин дээгүүр, харин Улаанбаатар хот, Орхон аймгийнхаас 4 дахин доогуур байна.

#### Эдийн засгийн макро бүсүүдийн хөгжлийн төвшний харьцуулсан үнэлгээ

(хүснэгт №1)

Бүсийн нэр	Үнэлгээний коэффициент
Баруун	1.00
Зүүн	1.50
Хангайн	2.40
Төвийн	2.80
Улаанбаатар	7.50

Эх сурвалж: Үндэсний Хөгжлийн Хүрээлэнгийн судалгаа

Дээрх үзүүлэлтээс Баруун болон Зүүн бүсийн аймгууд хөгжлийн төвшингөөр доогуур байгаа боловч ерөнхийдөө хөдөөгийн гэж нэрэлж болох 4 бүсийн аймгууд Улаанбаатар хотын хооронд хөгжлийн төвшин ихээхэн ялгаатай байгааг харж болно. Энэ шалтгаанаас үүдэлтэйгээр хөдөөнөөс төв рүү тэмүүлсэн нүүдэл одоог хүртэл зогсохгүй байна. Баруун, зүүн бүсийн аймгуудаас шилжин ирэгсдийн ихэнх нь малчид бөгөөд тэдний зонхилох хэсэг нь Улаанбаатар, бусад нь Эрдэнэт, Дархан, Сэлэнгэ аймгуудад ирж байршиж байна.

Төвийн нутгуудад хэт бөөгнөрөл үүссэнээр малын бэлчээр, хөрс ихээр талхлагдаж байгаль экологийн доройтол үүсэх шалтгаан болж

байна. Гэтэл нөгөө төв рүү нүүдэллэж явсан газарт нутаг бэлчээр эзэнгүйдэж, газар нутгаа бүрэн ашиглан хөгжил бий болгох хөдөөгийн хүн амын чадавхи мөхөсдөж, эдийн засгаа жигд тогтвортой хөгжүүлэх, бус нутгийн хөгжлийн бодлого алдагдахад хүрч байна. Эд бүгд нь төрөөс хөдөөд чиглэсэн цогц бодлого дутагдаж байгаатай холбоотой. Энэ нь төрөөс бүхнийг хариуцаж өгнө гэсэн үг биш.

Гагцхүү хөдөө хүн ам тогтвортой ажиллах нөхцөл бололцоог нь бүрдүүлэх, хууль эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэхэд анхаарах учиртайг хэлж буй юм. Өнөөдөр төр засгийн зүгээс хөдөөд зориулж, хөрөнгө оруулалт, зээл, тусламж өгөгдэж байгаа боловч тэр нь асуудлыг цогцоор шийдэхэд биш, бага багаар тарааж хүртээх байдлаар хийгддэг. Үүнд манай өнөөгийн засаг захиргааны нэгжийн тархай бутархай байршил, хэт үрэлгэн бүтэц ч нөлөөлж байгаа нь бас бодит үнэн юм. 2000 оны эхээр бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлагдаж, аймаг, сумдын хүрээнд бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийж сумдыг томруулж, бүлэг суурингийн төвүүд бий болгох асуудал боловсрогдож чиглэл гарсан боловч одоо бараг мартагдахад хүрээд байна. Энэ чиглэлд хөдөөгийн хүн ам зүйн бодлого, нийгэм эдийн засгийн цогц бодлого хэрэгжихээр тусгагдсан юм.

## 1. 1. ХӨДӨӨГИЙН НИЙГМИЙН АСУУДАЛ

Хөдөөгийн хөгжлийг тодорхойлогч нэг гол хүчин зүйл бол хүн амын нийгмийн асуудал юм. Хөдөөд хүн амын эрүүл мэнд, боловсролын болон зам харилцаа, эрчим хүч, мэдээлэл харилцаа холбооны асуудалд дорвитой өөрчлөлт гарахгүй байгаа нь төв рүү тэмүүлэх хүчний нэг гол шалтгаан болж байна. Аймаг, томоохон суурин, зарим сумдад орчин үеийн харилцааны үйлчилгээ бий болж, эрчим хүчээр хангагдаж эхэлж байгаа боловч түүний хүртээмж, хүрэлцээ хангалтгүй, тодруулбал, жинхэнэ хөдөөгийн хүн амд (малчид, тариаланчид) хүрч чадахгүй байна.

Хөдөөгийн хүн амын эмнэлэг үйлчилгээг сайжруулах, ялангуяа нарийн мэргэжлийн үйлчилгээ, эмчилгээ, оношлогоог хөдөөд ойртуулах нь чухал байна. Эдгээр үйлчилгээ дутагдалтайгаас хөдөөний хүмүүс Улаанбаатар хотод ирж онош тогтоолгох, нарийн мэргэжлийн эмчилгээ хийлгэх гэж ихээхэн зардал чирэгдэл болж буйн гадна тэдгээр хүмүүсийн нэлээд нь орон нутагтаа буцахгүй хотод суурьшиж, хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөн ихсэх нэг шалтгаан болж байна.

Хөдөөгийн сумдад нийт хүн амын 42.0 хувь нь байгаагийн 67.0 хувь нь хөдөө (багт)

амьдарч байна. Иймд сумдын эмнэлгийг орчин үеийн багаж төхөөрөмж, эм тариа, эмч мэргэжилтнээр хангах нь нэн чухал.

Эмч мэргэжилтний тоо /10000 хүн тутамд/

*Хүснэгт №2*

Мэргэжилтэн	Улсын дундаж	Хот	Хөдөө
Их эмч	27.3	47.3	17.5
Бага эмч	10.4	5.4	12.5
Сувилагч	31.1	42.3	25.6

Дээрх байдлаас харахад хөдөөгийн сумдад 10.0 мянган хүнд ногдох их эмчийн тоо улсын дунджаас 4.0 хувь, хотоос бараг 2.5 дахин доогуур байна. Сувилагчийн тоо сумын дунджаас 6.0 хувь, хотоос 11.0 хувь доогуур байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

Хөдөөгийн боловсролын хувьд ч гэсэн анхаарах зүйл олон байна. Малчдын хүүхдүүд сургуульд сурхын тулд олон хоногоор дотуур байр, ах дүү, таньдаг айлдаа, сумын төвд амьдардаг нь тэдний сурлагад муугаар нөлөөлөөд зогсохгүй, олон зуун хүүхдэд сургуулиа орхиж, боловсролгүй хүүхдийн тоо өсөхөд хүргэдэг.

Мал хувьчилсаны дараагаар сургуулийн насны хүүхдээ мал маллуулах зорилгоор сургуулиас нь гаргаж сургууль завсардах нь ихсэж байна. Хөдөөгөөс хотод шилжилт их буйн нэг шалтгаан нь хүүхэддээ чанартай боловсрол эзэмшүүлэх гэж эх эцэг нь хүүхдээ дагаж төвд ирдэг.

Судалгаанаас үзэхэд Улаанбаатарт шилжин ирэгсдийн бараг 30 шахам хувь нь дээрх замаар шилжин ирэгсэд байна.

Нэгэнт мал хувьчлагдаж, малчин хүн өмчийн эзэн болсон учир өмчөө арчилж хамгаалахад хүч дутагдаж, нөгөө талаас өмч, хөрөнгөө хүүхэддээ өвлүүлэх зорилгын үүднээс дээрх асуудал гарч байгааг буруу гэх аргагүй юм. Иймд *мал дээр гарсан хүүхдүүдэд гэрээр боловсрол эзэмшиүүлэх асуудлыг засаг, төр боловсролын төв байгууллагын зүгээс бодлого болгон хэрэгжүүлэх нь зүйтэй. Ер нь манайд ерөнхий боловсролыг зөвхөн танхимд хүүхдүүдийг бөвөгнөрүүлэн, сургадаг системийг ч харж үзмээр байгаа юм. Хөдөө мал дээр гарч буй хүүхдүүдэд танхимд сургадгаас дутахгүй тийм сургалтын арга системийг л бий болгох хэрэгтэй юм.*

Ийм нөхцөлд орчин үеийн боловсролтой малчдын залуу халаа бий болж, МАА-н үйлдвэрлэлийг зах зээлийн ухаанаар залж чиглүүлдэг менежерүүд бий болно. *Орчин үеийн малчин зөвхөн малаа малладаг төдийгүй, мал маллагааны арга технологио боловсронгуй болгох, малаа эдийн засгийн эргэлтэнд оруулах, түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх зэрэг арга ухааныг эзэмшиэн байх шаардлага тавигдаж байна.*

Энэ утгаар авч үзвэл малчныг зөвхөн малладаг утгаар биш үйлдвэрлэлээ өргөн хүрээнд эрхлэх мэдлэг боловсролтой *малчин-мэргэжилтэн, малчин-үйлдвэрлэгч бэлддэг*

**боловсрол сургалтын систем ч бий болгож болох юм.** Харин ийм сургалт үйлдвэрлэлээс хөндийрөлгүй явагдах ёстай. Хуучин социализмын үед **малчны сургууль гэж байсныг ч зах зээлийн эрэлттэй уялдуулж боловсронгуй болгон сэргээж болох юм**. Эндээс л хөдөөд жинхэнэ хөгжлийн үр таригчид гарч ирэх учиртай.

Хөдөө орон нутагт боловсролын талаар хийх нэг ажил бол дээд сургууль, коллеж, MCYT-үүдийг хөдөөд хэрэгцээ шаардлагыг харгалzan зөв байршуулах явдал юм. Одоогийн байдлаар их дээд сургуулийн бараг 80-аад хувь нь Улаанбаатарт байршиж, тэнд элсэлтээр олон зуун суралцагсад хөдөөнөөс ирж суралцан төгсөөд нутагтаа очих нь бараг үгүй байна. 200-аад их дээд сургуулийн 50 хүрэхгүй нь хөдөөд байгаа нь тун хангалтгүй үзүүлэлт.

Дээд сургуульд суралцагсдын бараг 80 гаруй хувь нь хөдөөнөөс ирж байгаагаас үзэхэд ойлгомжтой. Иймд их, дээд сургуулиудыг орон нутагт тараан байршуулах бодлого баривал хөдөөгийн хүн амын соёл боловсрол, тогтвортсуурьшилд нөлөөтэй болно.

Хөдөө орон нутагт уул, уурхай, барилгын үйлдвэр хөгжиж, хөнгөн хүнсний чиглэлийн боловсруулах үйлдвэрүүд бий болох, ирээдүйг харгалzan орон нутагт төрөл бүрийн мэргэжилтэй ажилчид бэлтгэх MCYT (хуучнаар TMC)-үүдийг шинээр байгуулах, хуучныг бэхжүүлэх нь тулгамдсан асуудал болоод байна.

Хөдөөгийн нийгмийн асуудлын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг бол хөдөөгийн хүн амыг эрчим хүч, харилцаа холбооны байнгын хангалт үйлчилгээгээр хангах асуудал юм. Энэ үйлчилгээ аймаг, томоохон суурины сумын төвөөс цааш гарч чадахгүй байна.

Ялангуяа хөдөөгийн хүн амын 50-иас илүү хувийг эзэлдэг малчдад нэн хангалтгүй байна. Мэдээ мэдээллээс хөндий байгаа малчид, тариаланчид зах зээлийн тухай үеийн үнэ ханшийн байнгын мэдлэгтэй байж, бараа бүтээгдэхүүнээ борлуулах, зах зээлийн харилцаанд суралцах боломж их дутмаг байна.

**Хөдөөгийн сумдын эрчим хүчний хангамж**

*Xуснэгт №3*

Бүс	Сумын тоо	Үнээс ЭХС-д холбогдсон	Хувь
Баруун	92	17	18
Хангайн	100	49	49
Төвийн	102	74	72
Зүүн	44	16	36

*ЭХС-д холбогдоогүй сумд нь дизель станцтай.*

Хангайн бүсийн аймгаас Баянхонгор аймгийн бүх сум Хөвсгөл аймгийн 24 sumaас 22 нь ЭХС-д холбогдоогүй байх жишээтэй. Зүүн бүсийн аймгуудад бас энэ ажил хоцрогдолтой байна.

Байдлаас харахад нийгмийн асуудал, дэд бүтэц болон бусад хөгжлийн асуудлаар Баруун,

зүүн бүсийнхэн хоцрогдонгуй байгаа нь анхаарал татаж байна. 2007 онд 11 аймгийн 59 сумыг гэрэл цахилгаантай болгоход зориулж 67 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулж уг ажил эхэлж буй нь сайн хэрэг. Энэ ажлыг улам эрчимтэй явуулж, хөдөөг (багийг) цахилгаанжуулах ажлыг хийх шаардлагатай. Хөдөөгийн малчдын зарим нь сүүлийн жилүүдэд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр

нар, салхины энергийг янз бүрийн сувгаар авч хэрэгжүүлэх, төрөөс үүнд чиглэсэн бодлогын үр дүнд зарим ахиц гарч байна.

2005 оны байдлаар нийт малчин өрхийн 40 хувь нь цахилгаантай, 35 хувь нь телевизортой болсон байна. Гэхдээ цаана нь үлдэж буй 60-70 хувь нь харанхуй, мэдээлэл авах боломжгүй байгаа нь анхаарах асуудал юм.

#### Улсын хэмжээний малчин өрхийн соёл ахуйн хангамжийн байдал

*Хүснэгт №4*

		Онууд			
		1990	1995	2000	2005
Mалчин өрхийн тоо(мян)		74.7	169.3	191.5	168.5
Өрхийн тоо (мян)	Цахилгаантай	11.2	19.1	20.4	67.7
	Телевизортай	-	16.8	24.6	60.1
	Автомашинтай	-	4.9	16.6	23.2
	Мотоциклтэй	16.3	26.7	31.7	37.4
	Трактортой	-	-	2.8	2.4
Малчин өрхийн тоонд эзлэх хувь	Цахилгаантай	15.0	11.3	10.6	40.2
	Телевизортай	-	9.9	12.8	35.7
	Автомашинтай	-	2.9	8.7	13.8
	Мотоциклтэй	21.8	15.8	16.6	22.2
	Трактортой	-	-	1.5	1.4

Малчин өрхийг цахилгааны ямар нэг найдвартай эх үүсвэрээр бүрэн хангах асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэх нь тулгамдсан зорилт болж байна. Энэ **асуудалд төр засаг, өмчийн эзэн малчид, тэдэнтэй ажил төрлийн холбоотой байдаг бизнесменүүд аль**

**аль нь анхаарал тавьж хандвал уг зорилт бүрэн хэрэгжих боломжтой.** Зарим сум суурингийн төв, малчдыг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах (нар, салхи) бодлогыг түлхүү барьж хэрэгжүүлэх нь зүйтэй.

## 1.2. ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨДӨӨД ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО

Хөдөө орон нутагт жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн (мах, сүү, тариа, төмс, ногоо), мал аж ахуйн гаралтай түүхий эдийг анхан шатны болон гүнзгийрүүлсэн боловсруулалт хийж, экспортлох, дотооддоо хэрэглэж импортыг багасгахад чиглэгдэх учиртай.

Дотооддоо үйлдвэрлэж болох, үйлдвэрлэж байсан хөдөө аж ахуйн гаралтай олон төрлийн бүтээгдэхүүнийг импортоор оруулж ирж байна. Мөн мал аж ахуйн гаралтай их хэмжээний түүхий эдээ боловсруулалт хийлгүйгээр гадагш нь гаргаж байгаа нь улсын эдийн засагт ихээхэн хохиролтойгоос гадна, малчид, тариаланчдын амьдралд сөргөөр нөлөөлж байна.

Газар тариалангийн зарим бүтээгдэхүүний импорт

Хүснэгт № 5

№	Нэр	1990	2002	2003	2004	2005
1.	Үр тариа /мян.тн/	-	139.2	61.5	114.9	97.5
2.	Гурил	27.7	96.9	75.2	79.3	103.9
3.	Төмс, хүнсний гогоо	-	41.4	30.4	32.4	28.1
4.	Цөцгийн тос /тн/	-	18.6	55.5	5.0	8.4

Манай улс 2005 оны байдлаар хэрэгцээт гурилынхаа 70 орчим хувь, төмс, ногооныхоо 20-30 хувь, гахай, шувууны мах, өндөгний 70-80 хувь, цөцгийн тос бараг зуун хувь импортоор оруулж ирж байгаа нь алтаа авдрандаа цоожилчихоод айлаас алт худалдаж авч байгаатай агаар нэг юм.

Дээрх бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж хэрэгцээгээ хангаж, импортыг багасгах бүрэн бололцоотой бөгөөд **энд нэг талаас төрийн идэвхтэй бодлого, нөгөө талаас үйлдвэрлэгчид (малчид, тариаланчид), бизнесменүүдийн ажил хэрэгч уялдаа холбоо, санаачлагага чухал байгаа юм. Төрөөс хувийн хэвшлийнхэнэй идэвх сонирхлыг өрнүүлэх, өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн хууль, эрх зүй, эдийн засгийн хөшүүргээр дэмжих бодлого явуулах нь чухал юм.**

Мал аж ахуйн үндсэн гол үйлдвэрлэгчид болох малчин өрхөд үйлдвэрлэгдэж байгаа мах, сүү, сүүн бүтээгдэхүүн зах зээлээс алслагдсан, унаа тээвэр, зам харилцааны боломж муугаас дотоодын үйлдвэр хэрэглэгчид хүргэж борлуулж чадахгүй зөвхөн тухайн өрхийн хэрэгцээг хангах төдий хэмжээнд байж, малчид малын ашиг шимээ бүрэн гүйцэд ашиглаж чадахгүй байна. **Эдгээр асуудлыг боловсруулах жижиг үйлдвэрүүдийг орон нутагт түүхий эдэд нь ойртуулж байгуулснаар л шийдвэрлэж чадна.**

Бэлчээрийн мал аж ахуйн нэг үндсэн чиглэл бол мах үйлдвэрлэлт, харьцангуй хямд өртөгтэй, экологийн цэвэр махны эрэлт хэрэгцээ дэлхийн зах зээлд их байгаа боловч мал аж ахуй эрхлэгчид, бизнесменүүд, төр засгийн аль алины идэвхтэй санаачлага, бодлого дутсанаас бэлэн байгаа их нөөц боломжийг алдаж буй нь нэн харамсалтай.

Монгол улс 1990 онд 25.8 сая малтай байхдаа 24.3 мян.тн мах экспортолж байсан бол 2005 онд 30 гаруй сая малтай болсон ч 1990 оноос бараг 3 дахин бага хэмжээний мах экспортолсныг харахад байдал ямар ч тайлбаргүйгээр ойлгомжтой байна.

Мах махан бүтээгдэхүүн болон мал аж ахуйн гаралтай бусад түүхий эдийг экспортод гаргах хэмжээг тогтвортой нэмэгдүүлэх нь нэг талаас валютын орлогыг нэмэгдүүлэх нөгөө талаас малыг эдийн засгийн эргэлтэнд оруулж малчдын орлогыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Малчид өнөөдөр малынхаа түүхий эдийг гадаад дотоодын тааралдсан худалдан авагчдад хямд үнээр буюу бараа таваарын солилцоогоор борлуулж байгаа нь явав ч зах зээлийн эрэлт шаардлагад нийцсэн үйл ажиллагаа биш.

Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах жижиг дунд үйлдвэрүүдийг байгуулах асуудлыг төрийн бодлогоор дэмжих явдал чухал байна. Одоогийн байдлаар ноос, ноолуур, арьс шир ямар ч боловсруулалтгүйгээр

экспортлогдож байгаа нь их хэмжээний ашиг орлого олох нөөц алдаж, улсын эдийн засагт үлэмж хохирол учруулж байна.

*Эдийн засгийн нөөцдөө тулгуурлаж, бус нутаг, аймаг сумдад мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах жижиг дунд үйлдвэрүүдийг бий болгох нь хөдөөгийн хүн амын орлогыг нэмэгдүүлж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах чухал арга хэмжээ болно.*

*Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах жижиг дунд үйлдвэрүүдийг бий болгоход төрийн зүгээс хувийн хэвшлийнхний сонирхол, санал санаачлагыг өрнүүлж, өрсөлдөөн бий болгох эрх зүй, эдийн засгийн механизмыг бүрдүүлж өгөхөд анхаарах ёстой. Нөгөө талаар орон нутагт түүхий эд бэлтгэх сүлжээ тогтолцоог бий болгох замаар асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй.*

#### **Санал:**

- УИХ-аар баталсан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, мянганы зам, эрчим хүчний хөтөлбөр, төрөөс Хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого зэрэг улс орны нийгэм эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэгдсэн бодлогын чанартай арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг засгийн газар онцгой анхааралдаа авах

- Бүсийн тулгуур төвүүдийг орон нутгийн хөгжилд нөлөө бүхий орчин үеийн дэд бүтэц, нийгмийн байгууламжтай томоохон төв болгон бэхжүүлэхэд хугацаа алдалгүй тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх. Тухайлбал

хамгийн сүүлийн үеийн тоног, төхөөрөмжтэй оношилгоо, эмчилгээний төвүүд, дээд сургууль, коллеж, соёл шинжлэх ухааны салбаруудыг эхний ээлжинд бий болгох г.м

- Хөдөөгийн сум, төвлөрсөн суурин, тосгодод найдвартай эрчим хүч, мэдээлэл холбооны үйлчилгээ бий болгох, малчдыг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр бүрэн хангаж, байнгын мэдээлэл авч байх боломжоор хангах

- Хөгжлөөрөө харьцангуй хоцрогдож байгаа баруун, зүүн бүс болон.govийн аймгуудын талаар төвлөрсөн хөрөнгө оруулалтыг түлхүү хийх бодлого барих. Аймаг орон нутгийнхан, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтын ажиллагаа тогтоох, орон нутгийн нөөц баялгаа бие даан ашиглаж хөгжилд хүрэх санаа, санаачлага гаргаж ажиллах

- Мал аж ахуй эрхлэгчид тэдний орлогын үндсэн эх үүсвэр болсон малын гаралтай түүхий эдээ бэлтгэж борлуулах үндсэн дээр малаа эдийн засгийн эргэлтэнд оруулах сонирхлыг төрүүлэх, урамшлын механизмыг бий болгох, түүхий эдийн чанараас шалтгаалсан үнийн урамшил, малчдад мал аж ахуйн үйлдвэрлэл, нийгмийн асуудлаа шийдэх хөрөнгө оруулахад нь зориулж банкны болон байнгын харилцагч түвш байгууллагынх нь

зүгээс хөнгөлттэй зээл олгох болон төрийн зүгээс үзүүлэх бусад урамшил, хөнгөлөлтийн механизмаар дэмжих

- Max, сүү, арьс шир, ноос ноолуур зэрэг мал аж ахуйн гаралтай түүхий эдийг малчдаар бэлтгүүлж, худалдан авдаг, тэднийг хэрэгцээтэй бараа, таваараар нь хангаж үйлчилдэг сүлжээ, тогтолцоо бий болгох. 2000-2004 онд ажилласан УИХ, засгийн газраас дээрх асуудлын талаар тодорхой чиглэл, шийдвэр гаргасан боловч хэрэгжсэнгүй. Үүнийг сэргээх талаар ч анхаарах нь зүйтэй.

- Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн анхан шатны болон зарим гүнзгийрүүлсэн боловсруулалт хийдэг жижиг, дунд үйлдвэрүүдийг орон нутагт бий болгох асуудлыг төр, үйлдвэр эрхлэгчид, бизнесменүүдтэй хамтран бодлогоороо зохицуулж шийдвэрлэх. Гадаад дотоодын зээл тусlamжийн хөрөнгийн зарим хэсгийг ч гэсэн энэ чиглэлд хандуулах

- Малын гаралтай түүхий эдийн чанар, ариун цэврийн шаардлагыг бүрэн хангасан байлгахын тулд мал эрүүлжүүлэх, мал эмнэлгийн арга хэмжээг шаардлагад нийцүүлэн авч явуулах

# ХОЁР МОНГОЛ ОРНЫ МАЛ АЖ АХУЙГ ТОГТВОРТОЙ ХӨГЖҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

## 2.1. МАА-Н САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

**Н**гөрсөн зуунд Монгол улсын мал аж ахуй нь хувийн өмчөөс нийгмийн, нийгмийн өмчөөс хувьд шилжсэн зэрэг, сөрөг үр дагавар хосолсон түүхэн үеүдийг дамжин ирсэн боловч ард түмнээ тэжээсэн баялаг, эдийн засгийн тулгуур бааз хэвээр байж шинэ зуунд орлоо. Хүн ам өсөж, малын гаралтай хүнсний уураг хомсдож байгаа нөхцөлд шинэ мянганыг мал аж ахуйгүйгээр төсөөлөх аргагүй. Байнга нөхөн төлжиж байдаг үнэтэй баялаг мал аж ахуйгаа эрхэм дээдэд үзэж, эрчимжүүлэн хөгжүүлэх асуудал Монгол төрийн бодлогын төвд байх учиртай. Ийм учраас Монгол улсын үндсэн хуульд, “Мал сүрэг үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтанд байна” гэж заасан билээ.

Мал аж ахуйн материаллаг баазыг бэхжүүлэхийн тулд газар тариаланг хөгжүүлж тэжээлийн аж ахуй, тэжээлийн үйлдвэр, өвс тэжээлийн сан, агуулах байгуулж, олон мянган хашаа байр барьж, худаг уст цэгийг гаргасан. Үүний үрээр мал сүрэг хашаа байраар хангагдаж бэлчээрийн 65 хувь нь устай болж жилд 250 мянган тонн тэжээл үйлдвэрлэх 25 үйлдвэр, 100 гаруй цехтэй, жилд дунджаар 994 мянган тонн тэжээлийн нэгжтэй тэнцэх тэжээл, үүнд зөвхөн хадлан 1154.0 мянган тонныг бэлтгэдэг байв. Энэ бүхэн нь ган,


зудын гамшгаас малчин, мал хоёрыг авран хамгаалахад ихээхэн үүрэг гүйцэтгэсэн.

Мал эмнэлэг үржлийн албаны тогтолцоог бүрдүүлж, шинжлэх ухаан, сургалтын байгууллагуудыг бий болгож олон мянган мэргэжилтнийг бэлтгэж чадсанаар малын чанар, ашиг шимийг дээшлүүлэх, үржлийн ажлыг явуулж олон арван шинэ үүлдэр, омог, хэвшлийн малтай болж үйлдвэрийн үндсэн түүхий эдийн нэр, төрөл, хэмжээ эрс нэмэгдсэн, мал эмнэлгийн өргөн цар хүрээтэй арга хэмжээ, үйлчилгээний дүнд малын эм бэлдмэлийн үйлдвэрлэл хөгжиж, малын өвчлөл, хорогдол эрс багасч, зарим тоо халдварт өвчний голомтыг устгаж чадсан. Өнгөрсөн зууны хоёрдугаар хагасын эхний 30 жилд 200 шахам сая малаа хүнсэнд хэрэглэж 7500.0 мянган тонн сүү үйлдвэрлэж, 660 мянган тонн ноос, 36 мянган тонн ноолуур үйлдвэрлэсэн нь мал аж ахуйн хөгжлийн нэгэн тодорхойлолт болон үлджээ.

## 2.2. МАЛЫН ТООНЫ ӨСӨЛТ, СУРГИЙН НӨХӨН ҮЙЛДВЭРЛЭЛ

Малын тооны өсөлт нь нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, мал маллагааны арга технологи, аж ахуйн хүч чадал, мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын хэмжээ зэргээс хамаарч ирэв.

**Нийт малын өсөлт  
(сая.толгой)**



1997 онд 31.5 сая, 1998 онд 32.9 сая, 1999 онд 33.5 сая, 2006 онд 34.5 сая болж мал их өссөн оргил үе байв. Бэлчээрийн мал аж ахуй байгалийн эрхшээлээс гарч чадаагүйн улмаас ган, зудын гамшигт хялбар нэрвэгдэж олноор хорогдож ихээхэн хохирол гарч байна. Ган зуд тохиолдсон 2 жилд 8.5 сая мал хорогдож, 12.5 мянган айл малгүй болсон.

**Малын өсөлт  
(төрлөөр сая.толгой)**

*Хүснэгт №7*

Он	1990	2001	2002	2003	2004	2005	2006
Бүгд сая.төг	25.8	26.1	23.9	25.4	28.0	30.4	34.5
Тэмээ мян.төг	537.5	285.2	253.0	256.7	256.6	254.2	252.6
Адуу мян.төг	2262.0	2191.8	1988.9	1968.9	2005.3	2029.1	2103.5
Үхэр мян.төг	2848.7	2069.6	1884.3	1792.8	1841.6	1963.6	2150.8
Хонь мян.төг	1508.3	11937.3	10636.6	10756.4	11686.4	12884.5	14671.5
Ямаа мян.төг	5125.7	9591.3	9134.8	10652.9	12238.0	13267.4	15305.0

Малын төрлөөр үзэхэд адuu, үхрийн өсөлт харьцангуй тогтвортой, тэмээн сүрэг ихээхэн хорогдож байна. Сүүлийн 10 жилд нийт малын тооны өсөлтийн 80 гаруй хувийг ямаа эзэлж 1990 оныхоос 3.6 дахин өссөн нь зах зээлд ноолуурын хэрэгцээ үнэ ихэссэнтэй холбоотой. Малчид ямаагаа өсгөх сонирхол их болсноор малын төрөл хоорондын тооны харьцаа эрс

өөрчлөгддэж 1990 онд нийт малын дотор хонь 58.3 хувь, ямаа 19.8 хувь, үхэр 11.0 хувь, адuu 8.8 хувь, тэмээ 2.1 хувь байсан бол 2006 онд хонь 42.3 хувь, ямаа 44.4 хувь, үхэр 6.2 хувь, адuu 6.0 хувь, тэмээ 0.7 хувь эзлэх болов. Нэг хотонд 3 хонь, 1 ямаа байсан бол одоо 1 хонь 1.04 ямаатай болжээ. Бог сүрэгт хонь, ямааны ийнхүү өөрчлөгдсөн харьцаа нь эерэг, сөрөг олон

талтай. Эрдэмтэд мэргэжилтнүүд судалж зохистой харьцааг тогтоох нь чухал. Манай малчдын уламжлалт туршлагаас үзэхэд 100 богийн дотор 25-30 ямаа байлгаж байсныг ч анхаарах л зүйл.

Монгол мал нь эрс тэс уур амьсгал, бэлчээрийн маллагаанд маш сайн зохицсон, хөдөлмөр зарцуулалт харьцангуй бага шаарддаг, экологийн цэвэр бүтээгдэхүүн өгдөгөөрөө дэлхийн бусад оронд үржүүлдэг, суурин маллагааны малаас давуу талтай. Эрт дээр үеэс уламжлагдан ирсэн ардын селекцийн аргаар малынхаа чанар удам угсааг сайжруулж ирсэн нь бэлчээрийн мал аж ахуйн нөхцөлд сонгомол арга байсан бөгөөд эдүгээ ч ач холбогдоо алдаагүйгээр барахгүй шинжлэх ухааны үндэстэй орчин үеийн үржил селекцийн ажлыг амжилттай явуулах суурь болж байна.

Манай орны аль ч бүс нутгийн шилмэл үүлдэр, омог хэвшлийг бататган сайжруулж, өсгөн үржүүлж тэднийг сайжруулагчаар ашиглах замаар нийт малын ашиг шимийг үлэмж нэмэгдүүлэх ихээхэн нөөц байгаа юм. Манай эрдэмтэд мэргэжилтнүүдийн идэвхитэй үйл ажиллагааны дүнд тус орны байгаль цаг уурын болон бүс нутгийн нөхцөлд зохицсон шинэ үүлдэр, үүлдрийн болон үржлийн хэсгийн арвин ашиг шимт мал бий болсон юм. Зах зээлд шилжих явцад мал сүрэг хувьд очсон нь сайн боловч мал аж ахуйн менежмент алдагдаж олон арван жилийн турш оюун ухаан, хүч хөдөлмөрөө зарцуулан байж буй болгосон арвин ашиг шимт үүлдэр, омгийн малын тоо

цөөрч, ялангуяа нарийн, нарийвтар ноост хонь, сүүний үхэр, ноос, ноолуурын ямаа, каракуль хонь тэдгээрийн эрлийз их цөөрсөн.

### Цэвэр эрлийз нутгийн омгийн болон сайжруулсан үүлдрийн малын тоо

	Хүснэгт №8				
Төрөл	1990	2002	2003	2004	2005
<b>Цэвэр үүлдрийн мал</b>					
Бүгд	506.0	645.9	1161.0	1211.3	1520.7
Үхэр	80.5	25.3	15.7	26.5	21.7
Хонь	333.6	504.2	975.3	1013.1	1205.2
Ямаа	91.9	116.2	170.0	171.7	293.8
<b>Эрлийз мал</b>					
Бүгд	1345.3	937.5	380.4	450.4	356.9
Үхэр	171.9	91.6	57.9	53.5	55.5
Хонь	837.4	545.5	68.1	73.7	53.9
Ямаа	336.0	300.4	254.4	323.2	247.5
<b>Нутгийн шилмэл омог</b>					
Бүгд	1240.9	11152.4	572.8	708.4	697.4
Тэмээ	5.0	5.2	5.2	5.3	7.3
Адуу	-	36.4	19.0	21.4	16.5
Үхэр	23.4	3.8	2.5	0.7	0.5
Хонь	1198.0	564.7	65.5	81.6	113.0
Ямаа	14.5	542.4	480.6	599.4	560.0

### 2.3. МАЛ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО, ЧИГЛЭЛ

Цаг агаарын эрсдэл, ган зудын давтамж жилээс жилд ихсэж байгаа асар уудам өргөн нутагт ашиг шим багатай олон тооны малыг байгалийн аясыг дагаж эрчимгүй аргаар эрхлэн

амьдрах нь нийгэм, эдийн засаг, аж ахуйн аль ч утгаараа ихээхэн хязгаарлагдмал болж байна.

Иймд мал аж ахуйг салбарын хувьд хөгжүүлэх бодлогын нэг гол чиглэл нь бэлчээрийн даац, түүнийг ашиглах боломж, байгаль цаг уурын хувьсал өөрчлөлттэй уялдан малын тоог харьцангуй хязгаартай өсгөх, чанар удам угсааг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх эрчимжилтийн арга хэмжээг тууштай явуулж, мал аж ахуйн бүтээгдэхүүнээр дотоодын үйлдэр, хүн амын хэрэгцээг хангах, экспортыг дэмжиж урамшуулах, ялангуяа экологийн цэвэр мах үйлдвэрлэлт түүнийг экспортыг эрс нэмэгдүүлэх явдал юм.

Монгол улсын хүн амын өсөлт, гадаад, дотоод зах зээлийн эрэлт хэрэгцээг харгалзан үзвэл XXI зуунд мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх асуудлыг үндсэн хоёр замаар шийдвэрлэх нь чухал юм.

***Нэгдүгээр зам нь*** Монгол оронд байгаль, экологийн нөхцөлдөө дасан зохицсон бэлчээрийн унаган мал болох Монгол малынхаа тоог зохистой хэмжээнд барьж мах, сүү, ноос, ноолуур, арьс, шир бусад түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж улс орныхоо дотоод хэрэгцээг хангах, гадаад зах зээлд нийлүүлэх хэмжээг үлэмж ихэсгэх; Байгаль цаг уурын нөхцөл эрс өөрчлөгдж, ган, зудын давтамж ойртож буй нөхцөлд малын тоог хязгааргүй нэмэх биш, бэлчээр, тэжээл, усан хангамж, бусад нөхцлийг бүрдүүлэх

замаар ашиг шимийг нэмэгдүүлэх чиглэл барих.

***Бэлчээрийн мал аж ахуй эрхлэх уламжлалт аргаа хадгалахын зэрэгцээ, түүнийг боловсронгуй болгох, мал, малчдаа эрсдлээс хамгаалах, ялангуяа өвлүүн хахир хатуу үед хагас суурин хэлбэрт аажмаар шилжих бодлого барих нь зүйтэй.***

Малчин хүн мал аж ахуйг дагнан эрхлэхийн зэрэгцээ өвөлжөө, хаваржааныхаа дэргэд малын тэжээл, төмс, хүнсний ногоо тариалах, малын гаралтай түүхий эдийг анхан шатны боловсруулалт хийх зэрэг ажлыг хослон эрхэлж, суурин амьдралын зарим элементийг аажмаар нэвтрүүлэх нь орчин цагийн малчин хүний амьдрал, нийгэм, ахуйн эрэлт шаардлагад нийцэх учиртай.

***Хоёрдугаар зам нь*** эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж нэг малаас гарах бүтээгдэхүүний /мах, сүү, өндөг, ноос/ хэмжээг хэд дахин нэмэгдүүлж бага газар эзэмших бүтээмж ихтэй цөөн мал үржүүлж хэрэгцээгээ хангах, экспортыг өсгөх.

#### 2.4 МАЛ АЖ АХУЙГ БҮСЧЛЭН ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО

Монгол орны газар зүйн онцлог, бэлчээрийн нөөц, малын тоо, төрөл, боловсруулах үйлдвэрийн байршил, түүхий эд бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлт зах зээлийн ойртолт, дэд бүтцийн байдал, хэт төвлөрлийг сааруулах зэрэг олон хүчин зүйлийг харгалзан мал аж ахуйг хөгжүүлэх бодлогыг

Монгол Улсын Их Хурлаас 2001 онд баталсан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нягт уялдуулан явуулах шаардлагатай

**1. Зүрийн бүс.** Энэ бүсэд Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймаг багтана. Энэ бүсэд улсын нийт бэлчээрийн 18.0 хувь малын 13.8 хувь нь байгаа. Нийт үхрийн 19.01 хувь, адууны 23.53 хувь, тэмээний 9.13 хувь, хонини 15.12 хувь, ямааны 10.32 хувь нь энэ бүсэд байна. Мал нь цөөн учраас бэлчээр ашиглалтын түвшин 26 хувь байна. Энэ бүсийн мах боловсруулах, ноос угаах, хивс хийх үйлдвэрүүдийг хүчин чадалд нь хүргэж ашиглах, арьс ширэн бүтээгдэхүүний үйлдвэр бий болгох шаардлагатай. Ойрын ирээдүйд газрын тосны үйлдвэрлэл хөгжих төлөвтэй. Энэ нь хүн ам олширч, тосгон, суурин дэд бүтэц бий болгох боломж бүрдүүлнэ. “Мянганы зам”-ын дагуу суурин аж ахуйн хэлбэр хөгжих боломжтой. **Энэ бүс нь Монгол улс болон зүүн хойд Азиийн орнуудыг хамарсан “Түмэн гол” төслийн хүрээнд мал аж ахуйн бүтээгдэхүүн экспортлоход хамгийн доть байх юм.**

Бүсийн хэмжээнд буй болсон ашиг шим сайтай малын үржлийн баазыг ашиглаж махны үхэр, адуу, мах өөхний хонь, ноолуурын ямаа зонхиlj үржүүлэх нь илүү ач холбогдолтой. Энэ бүсэд Дорнод талын махны хэвшилийн үхэр, Барга, Үзэмчин хонь, нарийвтар ноост “талын цагаан” хонь, Баяндэлгэрийн улаан ямаа, галширын адгуу гээд олон шилдэг үүлдэр, омгийн тархалтын хүрээг өргөтгөх, сайжруулагчаар ашиглах замаар **малын чанарыг сайжруулж**

**түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг 15-20 хувиар нэмэгдүүлэх боломжтой. Мөн их хэмжээний өвс бэлтгэж говийн аймаг, суманд нийлүүлэх, өвс, тэжээл экспортлох боломжтой.**

**2. Баруун бүс.** Энэ бүсэд Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-алтай, Завхан аймаг хамрагдах юм. Энэ бүсэд улсын нийт бэлчээрийн 26.0 хувь, малын 30.4 хувь, нийт үхрийн 21.48 хувь, адууны 17.92 хувь, тэмээний 26.7 хувь, хонини 29.98 хувь, ямааны 34.11 хувь нь байдаг. Бэлчээр ашиглалтын түвшин өндөр. Энд ноос, ноолуур угаах, цэмбэ хийх, мах, арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн хүчин чадлыг ашиглах, **мах, ноос, боловсруулах жижиг дунд үйлдвэрүүдийг шинээр нэмж бий болгох нь бүсийн мал аж ахуйн чиглэлтэй уялдах бөгөөд зах зээл нь малчадад ойртох, ялангуяа Улаанбаатар, Дархан хүртэл мал тууварлах дарамтаас ангижсрах ач холбогдолтой.** Энэ бүс нь ОХУ, Казакстан, БНХАУ-д мал аж ахуйн хагас буюу бүрэн боловсруулсан бүтээгдэхүүн гаргах, хэрэгцээт бараа авах зэрэг худалдаа, эдийн засгийн харилцааг өргөтгөх хамгийн ойр тохиромжтой. Тэс, Эрдэнэбүрэн, Хархираа, Баянтооройн тэжээлийн аж ахуй байсан буйрин дээр усалгаатай нөхцөлд хадлан, тариалан эрхэлж бүсийн хэмжээний малын тэжээлийн хангамжийг сайжруулах арга хэмжээ авах боломжтой.

**Баруун бүсийн экологийн өвөрмөц нөхцөлд зохицсон нутгийн шилдэг омгийн малыг цаашид үргсүүлж мах, ноос, ноолуурын үйлдвэрлэлийг**

**нэмэгдүүлэх гол бодлого байх ёстой.** Энэ бүсэд Говь-Алтай, Баяд, Керей, Сутай, Сартуул хонь, Өлгийн улаан, Алтайн улаан, Дөрвөлжингийн хар, Тэс, Мянгадын адуу, хос зогдортой Төхөм Тунгалагийн тэмээ, Уулын сарлаг зэрэг нутгийн малын баялаг генофонд бий. Мөн торгууд хонь, уулын бор үүлдрийн ямаа, сүүний чиглэлийн тулман хөхт ямаа байгаа. Эдгээрийг үржил, селекцийн ажилд өргөн ашиглаж малын чанар, ашиг шимиийг нэмэгдүүлэх нь илүү ач холбогдолтой.

**3. Хангайн бүс.** Энэ бүсэд Хөвсгөл, Булган, Орхон, Өвөрхангай, Архангай, Баянхонгор аймаг хамаарна. Энд улсын нийт бэлчээрийн 23.0 хувь, малын 33.2 хувь нь байгаа. Нийт үхрийн 41.55 хувь, адууны 34.20 хувь, тэмээний 15.54 хувь, хонины 33.24 хувь, ямааны 32.09 хувь нь энэ бүсэд байна. Бэлчээр ашиглалтын түвшин өндөр. Энэ бүсэд *мал аж ахуйн түүхий эд боловсруулах үйлдвэр сүл хөгжссон, гадаад зах зээлд шууд харьцах зах зээл хязгаарлагдмал.* Үхэр, адuu ихтэй бүс нутгийг харгалзан мах боловсруулах орчин үеийн технологийн жижиг, дунд үйлдвэр байгуулах. Өндөр уулын бэлчээрийг ашиглан сарлагийн аж ахуйг эрчимтэй хөгжүүлэх, сарлагийн сүү боловсруулах /брывн хийх/, сарлагийн хөөвөр, хялгас, ширэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжүүлж сарлагийн давуу талыг дэлхийд харуулах.

Бүс нутгийн онцлогт зохицсон Байдраг, Дархад, Тамир, Хотонт үүлдэр, үүлдрийн

хэсэг, омог хонийг үржүүлэх, тархалтын хүрээг тэлэх, сайжруулагчаар өргөн ашиглах, Залаа жинстийн цагаан ямаа, Дархадын цагаан адууг өсгөх, махны чиглэлийн Хонгорын үхэр, Сэлэнгэ үүлдрийн үхрийн үржлийн цөм сүргийг өсгөж нутгийн үхрийг сайжруулах үржил, селекцийн ажлыг зохион байгуулах, тайгын бүсэд Цаа бугын удмын санг хамгаалан өсгөх, Монгол, Сарлагийг эвцэлдүүлж мах, сүүн ашиг шимээр 25-30 хувиар давуу хайнаг гаргаж ашиглах өргөн боломжтой.

Өндөр уул, тагийн бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ Булганы Санкар, Сэлэнгэ, Хөвсгөлийн Тариалан, Архангайн Төвшрүүлэх, Хотонт, Өвөрхангайн Хархорин зэрэг суманд тариалан хөгжүүлэх хадлан тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлж бүсийнхээ.gov нутгийн болон өндөр уулын суманд гурил, төмс, хүнсний ногооны хэрэгцээг хангах тэжээлийн нөөц бий болгох үйл ажиллагааг хөгжүүлэх нь чухал.

**4. Төв бүс.** Энэ бүсэд Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Дундговь, Дорнговь, Өмнөговь, Говьсүмбэр аймаг хамаарна. Энд улсын нийт бэлчээрийн 23.0 хувь, малын 21.8 хувь нь байгаа. Нийт үхрийн 15.42 хувь, адууны 23.52 хувь, тэмээний 48.43 хувь, хонины 20.93 хувь, ямааны 22.83 хувь нь энэ бүсэд байна. Энэ бүсийн хойт болон төв хэсэгт бэлчээр ашиглалтын түвшин өндөр,.gov нутагтаа малын нягтрал бага. Энэ бүсд газар тариалан илүү хөгжиж мал аж ахуйн гаралтай

түүхий эд боловсруулах олон үйлдвэр төвлөрсөн зэрэг нь бүсийн хөгжилд түлхэц болох нөлөөтэй.

*Энэ бүсд мал аж ахуйг хоёр чиглэлээр хөгжүүлэх шаардлагатай. Газар тариалан хөгжсөн, байр, тэжээл, усаар хангах боломжтой болон хот орчмын нутагт саалийн болон махны үхэр, нарийн, нарийвтар ноост хонь, гахай, шувууны аж ахуйг хагас суурин, суурин хэлбэрээр хөгжүүлэх, ийм хэлбэрээр эрчимжсэн мал үржүүлэх иргэд, аж ахуйн нутаг бэлчээрийг гэрээгээр эзэмшүүлж таримал хадлан, бэлчээр бий болгох, тэжээлийн цех байгуулах, худаг гаргах, орон сууц, малын дулаан байр барих, эрчим хүчтэй холбоотой болох нөхцөл бүрдүүлэх шаардлагатай. Энэ бүсийн өмнөд говь нутгаар тэмээ, ямаа, адууны аж ахуйг зонхицж бэлчээрийн аргаар эрхлэх тохиромжтой.*

Энэ бүсд мах сүүний /Сэлэнгэ, Алатау, Хар тарлан, Шар тарлан/ үхэр, нарийн нарийвтар ноост /Хангай, Орхон, Ерөө, Жаргалант/ хонь, ноос ноолуурын /Өнжүүл, Говь гурван сайхан/ ямаа, Буржгар арьсны чиглэлийн /Сүмбэр үүлдэр/ хонины ашиг шимтэй эрчимжсэн мал аж ахуйн суурь бааз нэгэнт бий болсон учраас тэдгээрийн удмын санг хамгаалах, үүлдрийг сэргээж сайжруулах, тэжээл, байр, усаар бүрэн хангаж нэгжийн бүтээмжийг 2-3 дахин нэмэгдүүлэх явдал чухал. “Ханын хэцийн хүрэн”, “Галбын.govийн улаан” тэмээний шилдэг омгийн цөм сүргийг өсгөж сайжруулагчаар ашиглах тэмээний ноосны чанар, гарцыг ахиулан, сүүлэг байдлыг нэмэгдүүлэх боломжтой.

Тэмээний сүү, тавхай зэрэг үнэт бүтээгдэхүүнийг боловсруулж экспортын Монгол брэнд болгох чиглэлээр ажиллах.

*Биологийн нөөцийг ашиглан арвин ашиг шимтэй цөөн мал үржүүлж, зах зээлд өрсөлдөх чадвартай болохын тулд энэ бүсийн хойд хэсэгт малын тооны өсөлтөөс илүү ашиг шимийн чанар, гарцыг дээшлүүлэхд анхаарч богино хугацаанд их бүтээгдэхүүн үйлдвэрлэж, хурдан борлуулж, эргэлтийг түргээтгэх зах зээлийн шаардлагад нийцүүлэх нь чухал. Бүсийн хадлан, тариалан ихтэй нутгаас тэжээл бэлтгэж говийн аймаг, сүмдад нийлүүлэх таатай нөхцөлтэй юм.*

*Улаанбаатарын бүс.* Нийт мал сүргийн 0.8 хувь нь байгаа. Бэлчээрийн багтаамж, даац бага, хүн ам их төвлөрсөн. Хүн амын сүүн хэрэгцээг хангахын тулд дунджаар 3000 л сүү саалгадаг 45 мянган үнээтэй байх шаардлагатай байна. Энэ бүсэд сүүний үхрийн төрөлжсөн фермерийн аж ахуй, өсвөр үхэр, хонь, адту бордох жижиг, дунд хэмжээний талбай байгуулах, гахай, шувууны үйлдвэржсэн технологитой аж ахуй, төмс хүнсний ногооны аж ахуй бий болгох шаардлагатай. Тодорхой хэмжээний газрыг өмчилсөн буюу эзэмшсэн, бие даасан аж ахуй нэгжүүд үүсэн хөгжсөн байх юм. Ингэснээр хүн амыг жилийн турш мах, цэвэр сүү, хүнсний ногоогоор хангах, жилийн 3-8 сар хүртэлх хугацаанд хүн амын хэрэгцээнд шинэ мах нийлүүлж байх боломж бүрдэх юм. Бусад бүстэй харьцуулбал энэ бүсэд хүн ам харьцангуй суурьшсан. Зам, эрчим

хүч, холбоо, эмнэлгийн үйлчилгээ сайжирсан, малчин хотын хүнээс ялгагдахгүй амьдрал ахуйтай болсон байх юм. Энэ *бүрсэд газрын үр шимийг ашиглаж, тэжээлийн ургамал тариалж, бүрэн төгс найрлагатай тэжээлийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлснээр сүүний үхэр, гахай, шувуу, бордлогын малын физиологийн хэрэгцээт бодисын хангамж сайжирч экологийн* хувьд цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэх баталгаа бий болох юм.

## 2.5. МАЛ АЖ АХУЙ ЭРХЛЭХ ХЭЛБЭР, ЭРЧИМЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Мал сүрэг үндсэндээ хувьчлагдсан учраас шинэ зуунд өрхийн аж ахуйн зэрэгцээ хувьцаат компани, хоршоо, нөхөрлөл, фермерийн болон төрийн өмчийн хэлбэрээр мал аж ахуй эрхлэх нь зайлшгүй.

Мал аж ахуйг эрчимжүүлж тогтвортой хөгжүүлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ байнга нэмэгдүүлж зах зээлийн хэрэгцээ хангах гол хүчин зүйл нь газар бэлчээр эзэмших, өмчлөх, зохистой ашиглах явдал юм. Газар төрийн өмч, бэлчээр нийтийн эзэмшил, мал хувийн өмч байгаа нь хоорондоо зөрчилдөж, байгалийн нөөцийг гамтай эдэлж, хамгаалах, зохистой ашиглах, сэргээн сайжруулах ажил эзэнгүйдэж байна. Иймд нэг хот айл, нэг нутгийнхны хүрээнд газар нутгийг урт хугацааны гэрээ, түрээсээр эзэмшүүлэх ажлыг эхний ээлжинд зохион байгуулах шаардлагатай. Хот айлын болон малчдын бүлгүүд, аж ахуйн нэгж газар нутгаа гэрээгээр

эзэмших нь газрыг зөв зохион байгуулах, бэлчээрийг хамгаалах, зохистой ашиглах, сайжруулах ажлыг өөриймсөг сэтгэлээр хариуцан хийж тухайн газар нутагтаа байх малын тоо, төрлийг тохируулж, байр, хашаа барих, худаг гаргах, тэжээл үйлдвэрлэх, таримал бэлчээр бий болгох бололцоотой болно.

Малын тоо жилээс жилд өсч байгаатай уялдан малын тэжээл тариалж бэлтгэх ажлыг эрс нэмэгдүүлэх шаардлага тавигдаж байна. Энд юуны өмнө өмчийн эзэн малчин малаа байгалийн эрсдлээс хамгаалах, зун намрын тарга хүчийг нь хадгалахын тулд хүрэлцээтэй тэжээл бэлтгэх ажлыг малчид хэсэг бүлгээрээ хамтарч зохион байгуулах нь илүү үр дүнтэй болно. Бэлтгэж байгаа тэжээлийн бүтцэд ч анхаарах шаардлагатай байна. Бэлдэж буй тэжээлийн 80 гаруй хувь нь өвс зэрэг бүдүүн тэжээл эзэлж байна. Ер нь өвс хадлан л бэлтгэвэл болоо гэдэг ойлголт ч түгээмэл байна. Байгалийн өвс хадлан бол малын зөвхөн голыг зогоож, амьд байлгах төдий тэжээл юм. Малд хамгийн их шаардлагатай хүчит тэжээл ердөө 0.7 хувь байгаа нь нэн хангалтгүй юм. Цаашид малд нэмэгдэл тэжээлийн хэлбэрээр өгдөг хүчит тэжээлийн хэмжээг нэмэгдүүлэх. Энэ талаар малчид өвөлжөө, хаваржааныхаа хөлд овьёös зэрэг ургамлыг тариалж болох юм. **Малчид өөрсдийнхөө хэрэгцээт тэжээлийг бэлтгэхийн сацуу баг, сум, аймаг, улсын тэжээлийн нөөц бэлтгэх нь онцгой ач холбогдолтой.**

Мал аж ахуйг эрчимжүүлэх бодлого нь зөвхөн байгалийн бэлчээрийг шүтэж түүний хараат байдалд байхаас гарч бэлчээр хадланг сайжруулах, таримал хадлан, бэлчээр бий болгох, бэлчээрийг хамгаалж, хуваарьтай ашиглах, сэлгэж амраах зэрэг дэвшилт хэлбэрт шилжих, хадлан өвс, хүчит болон шүүст тэжээл бэлтгэж, хүйтний улиралд уураг ихтэй нэмэгдэл тэжээлээр малаа бүрэн тэжээдэг дэвшилт арга технологи нэвтрүүлэхэд чиглэгдэх ёстой. *Мал аж ахуйг эрчимжүүлэх З чиглэлийг хэрэгжүүлэх боломжтой юм.*

### *1. Бэлчээрийн монгол мал сүргийг*

*эрчимжүүлэхдээ малын чанар, ашиг шимиийн* түвшинг дээшлүүлэх, үржлийн ажлыг зохион байгуулах, тэжээл, байр, усан хангамжийг сайжруулах үйл ажиллагааг явуулж нөөцийг бүрэн ашиглахад илүү анхаарвал зохино.

Өвөл, хаврын улиралд тэжээл дутагдаж бие маш бодын хэрэгцээг хангаж чадахгүйгээс болж мал ихээхэн турж, маш, сүү, ноос, ноолуурын гарц, чанар нь буурч байгаагийн зэрэгцээ олон тооны мал хорогдож байна. Ингэж алдаж буй нөөцийг ашиглаж чадах нөхцөл бүрдүүлэх нь эрчимжүүлэх гол арга болно.

Монгол хонь үржүүлдэг аж ахуй бэлчээрийн маллагааны аргыг хэрэглэн сүргийн дотор хээлтэгчийн хувийн жинг 45-48 хувьд байлгаж, өсвөр хонийг 18-20 сартай болсны дараа мал бэлтгэлд нийлүүлэх нь ашигтай. Тэжээл, усаар хангасан нөхцөлд хургыг

эрчимтэй өсгөн бойжуулж зарим хэсгийг тухайн онд нь багтаан борлуулах дэвшилт хэлбэрийг нэвтрүүлэх нь чухал.

*2. Эрчимжссэн мал аж ахуйг хөгжүүлэхдээ арвин ашиг шимтэй, бүтээмж ихтэй үүлдэр, удам, бүлийг бий болгож, түүнд нэн тохирсон байр, тэжээл, усны хангамж, арчилгаа маллагааны нөхцөл бүрдсэн эрчимжсэн технологи хэрэглэх, тухайн малын биологийн чадавхийг дээд зэргээр илрүүлж, ашиглах нь чухал юм. Ашиг шимиийн тодорхой чиглэлээр төрөлжсөн арвин ашиг шимтэй хонины аж ахуйд сүргийн дотор эм хонийг 55-65 хувьд барьж, хургыг эрчимтэй бойжуулж тухайн жилд нь борлуулах, махны үхрийн аж ахуйд өсвөр үхрийг 18 сартайд мах бэлтгэлд өгөх технологи нэвтрүүлэх нь малчин хүн малаа эдийн засгийн эргэлтэнд түргэн оруулж, байнгын орлоготой байх ач холбогдолтой.*

*3. Үйлдвэржссэн мал аж ахуйг хөгжүүлэхдээ ашиг шимээр өндөр гахай, шувуу, саалийн үнээг нэн тохиромжтой орчинд жилийн турш байранд маллаж, тэжээх, услах, арчлан маллах, түүхий эд бүтээгдэхүүн авах зэрэг бүх үйл ажиллагааг бүрэн механикжсан аргаар гүйцэтгэх дэвшилт технологийг хэрэглэх нь тохиромжтой.*

### 2.6. БЭЛЧЭЭР АШИГЛААТЫН БОДЛОГО

Монголчууд олон зууны турш мал аж ахуйг эрхлэхдээ зөвхөн байгалийн бэлчээрийг шүтэн биширч ашиглаж ирсэн түүхтэй.

Газар бол төрийн өмч боловч тодорхой хариуцах эзэнгүй учраас бэлчээрийг замбараагүй ашиглаж, нийтийн дунд эзэнгүйдэхэд хүрээд байна. Бэлчээрийг эзэмших, ашиглах, өмчлөхтэй холбоотой асуудал нь бүс нутгийн онцлог, хүн ам, мал сүргийн нягт сийрэг байдлыг харгалzan дараах хэлбэрээр байж болох юм.

- Бэлчээрийн газрыг удаан хугацааны гэрээгээр эзэмшүүлэх, хамгаалах, зохистой ашиглах харьцааг зохицуулах эрх зүйн орчин бүрдүүлэх. Бэлчээр ашиглалтын талаар дагнасан хууль гаргах;
- Бэлчээрийн даацыг зөв үнэлэх, нүүдэл суудлыг зохицуулах хяналт тавихад малчид, малчдын бүлгийн оролцоог хангах;
- Газартaa хөрөнгө оруулж бэлчээрийг сайжруулж, зохистой ашиглаж, хашиж хамгаалсан малчдыг хөхүүлэн дэмжих;
- Өвөл, хаврын бэлчээрийг зун намар нөөцлөх нөхцөл бүрдүүлэх;
- Таримал бэлчээр, хадлан бий болгохыг дэмжих;
- Бэлчээрийн газрыг эзэмшүүлэх, ашиглуулах хэлбэр нь өрхийн аж ахуй, хот айлын хүрээнд байх нь илүү тохиромтой.

## 2.7. МАЛЫГ БАЙГАЛИЙН ЭРСДЛЭЭС ХАМГААЛАХ БОДЛОГО

Бэлчээрийн мал аж ахуй эрхлэхэд харьцангуй бага зардал гаргах, байгаль орчинд халгүй байх сайн талтай боловч мал сүрэг нь байгалийн тааламжгүй нөлөөлөлд өртөмтгий, байгалийн

бэрхшээлийг сөрөн тэмцэхэд малчин хүний биесийн хүч, сэтгэлийн тэнхээ их шаардсан хүнд, аз туршсан, эрсдэлтэй. Ийнхүү тохиолдох эрсдэл нь байгалийн эдийн засгийн, нийгмийн байдлаас шалтгаалдаг байна.

Цаг агаарын тааламжтай нөхцөлтөй хэвийн жилд бэлчээрийн мал өвөл, хавартаа тэжээл, ус дутагдсанаас /ялангуяа уурагт тэжээл/ шалтгаалж ихээхэн турж үүний улмаас ашиг шим нь багасч өлбөрч, өвчилж зүй бусаар хорогддог. Мөн ган, суд, шуурга, хүйтэн бороо гээд байгалийн гэнэтийн аюултай үзэгдэл үе үе тохиож мал аж ахуйд ихээхэн хохирол учруулдаг. Уур амьсгал дулааран хэт халалт болсноос олон булаг шанд, гол горхи, нуур цөөрөм ширгэх, тасалдах аюултай үзэгдэл тохиож хүн, мал усны гачаалд ордог болов. Уур амьсгалын урьдчилсан төлөв байдлаас үзэхэд хуурайшилт үргэлжилж, зарим бүс нутаг экосистемийн өөрийгөө нөхөх чадвар улам буурч зундаа мал тэжээхэд ч хүрч мэдэхээр байна. Мал хувьчлагдаж хувийн өмчид байгаа учраас малынхаа шимиийг хүртсэн эзэн хүн эргээд газартaa хөрөнгө оруулж, малынхаа тэжээл, ус байрны хангалт, үргүүлэг,mallагаа, арчилгааг сайжруулах шаардлагатай. Эрсдэл их, бага байх нь мал аж ахуйдаа хөрөнгө оруулалт хир хийснээс шалтгаалах юм. Манай улсад зудын аюул давтамж ихтэй, ойр ойрхон тохиолдож үргэлжлэх хугацаа урт, учруулах хохирол илүү байгаа. Ган зудын аюулаас хохирол багатай гарах арга хэмжээг цаг алдалгүй авахад малчид, төр засаг аль аль нь анхаарах ёстай.

- Ган зудын аюулаас сэргийлэх, хохирол баатай давах бодлого, чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээг улс, аймаг, баг, аж ахуй нэгжийн хэмжээнд боловсруулсан байх, хууль ч гаргаж болох;

- Өрх бүр өвөл, хавар малдаа хүрэлцэхүйц өвс, тэжээлийн нөөцтэй болж нэг хонь толгойд 30 тэжээлийн нэгж тэжээл бэлтгэх, малыг 11-р сараас дараа оны 5-р сар хүртэл нэмэгдэл тэжээлээр тэжээх, малын тэжээллэг, маллагааны дэвшилт технологи нэвтрүүлэх;

- Улс аймаг, сум, багт аюулаас хамгаалах өвс тэжээлийн нөөц буй болгох. Улсын нөөцөд жил 2 сая тонн тэжээлийн нэгжийг бүрдүүлэх /1.5 сая тонн өвс, 300 мянган тонноос доошгүй холимог, багсармал тэжээл/;

- Худаг уст цэг гаргах тусгай сан байгуулах, суваг, шуудуу татах, цас, бороо, үерийн усыг ашиглах, усны эхийг хамгаалах, гол горхины усны тасалдлыг зогсоох замаар усны хангамжийг шийдвэрлэх;

- Мал аж ахуйд даатгалын систем бий болгож үржлийн малаа даатгуулсан малчдад хохирол гарсан хойно нь бус, хохирол гарахаас нь сэргийлж туслан дэмжих, хөнгөлөлт үзүүлэх хөшүүрэг бүрдүүлэх

- Малын чанар сайжруулах, хадлан, таримал тэжээл усны хангамжийг нэмэгдүүлэх ажлыг гадаад орон, олон улсын байгууллагын төсөлд хамруулж дэмжлэг үзүүлэх, урт хугацааны зээл тусламж авч тэжээл үйлдвэрлэлийг хөгжүүлж, хадлан, тэжээл бэлтгэх, бэлчээр тордох сайжруулахад нь туслах

- Мал хамгаалах тухай, бэлчээрийн газрыг эзэмшүүлэх, ашиглалтыг зохицуулах тухай,

мал аж ахуй бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн тухай хууль гаргаж мал аж ахуй, үйлдвэр эрхэлдэг аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн хооронд үйл ажиллагаа, үүсэх харилцааг зохицуулах эрх зүйн таатай орчин бүрдүүлэх

- Малын орлогын албан татвар, бэлчээрийн болон газрын төлбөр зэрэг олон янзын татвар, төлбөр хураамжийг нэгтгэж малчдад газар нутгийг удаан хугацаагаар хариуцуулж, эзэмшүүлж, ашиглуулсны төлбөртэй тогтолцоонд шилжих

- Бэлчээрийн газрыг малчдын хот айл, хамтлаг бүлгүүдэд болон бүтээмж ихтэй мал аж ахуйг суурин хэлбэрээр эрхэлдэг фермерийн болон өрхийн аж ахуйд удаан хугацааны гэрээгээр эзэмшүүлж түүнийг зохицуулсан эрх зүйн орчинг бий болгох

## 2.8. ДҮГНЭЛТ, САНАЛ

- 1990 ээд оны эхээр мал хувьчлагдаж, малчид малынхаа бүрэн эзэн нь болж, аж ахуйгаа өөрийн тааллаар чөлөөтэй эрхлэх боломж бий болж, энэ нь үнэхээр малын өсөлт, чанарт эерэгээр нөлөөлсөн сайн талтай ч олон арван жил төрөөс бүх зүйлийг дээрээс чиглүүлж зааж байсны үр дүнд бий болж тогтсон бэлэнчлэх сэтгэлгээ малчдын ойлголтод эдүгээг хүртэл байгаа. Нөгөө талаас зөвхөн мал хувьчилснаар дээр дооргүй сэтгэл ханаж, зах зээлийн аргыг нь бүрдүүлэх талаар өмчийн эзэн, ялангуяа төрийн зүгээс оновчтой цогц бодлого авч явуулаагүйгээс хөдөөгийн хөгжил нийтдээ хоцрогдонгуй, түүний дотор

хөдөөг бүрдүүлэгч гол цөм хөдөө аж ахуй, малчдын хувьд төдийлэн ахицтай хөгжил дэвшил гараагүй өдий хүрэв. Энэ бүгдийн шалтгаан нь хөгжлийн их ялгаа. Өөрөөр хэлбэл төвд эмнэлэг, сургууль, эрчим хүч, харилцаа холбоо зэрэг нийгэм, дэд бүтцийн үйлчилгээ илүү хөгжсөнд байна. Эрвээхэй дэнгийн гэрэл рүү тэмүүлдэг адил хүн хөгжил рүү тэмүүлдэг мэдрэмж өнөө үед улам бүр их болж буй нь жам ёсны асуудал. Гагшүү энд төрийн тодорхой чиглэл зорилготой цогц бодлого хэрэгтэй. Нөгөө талаас өмчийн эзний зүгээс тавих анхаарал, санаачлага ч дээрхээс дутахгүй чухал. Энэ хоёрын хамтын чармайлтын уулзвар дээр хөгжил бий болно.

• ХХI зуунд мал аж ахуй эрхлэх гол чиглэл нь урт удаан хугацаанд эрхэлж ирсэн бэлчээрийн мал аж ахуйн хэлбэр хадгалагдах боловч дэлхий нийтийн чиг хандлага, зах зээлийн жаяг дэгийг дагаж боловсронгуй болгож хөгжүүлэх нь мэдээж. Энэ юуны өмнө ган, зуд зэрэг байгалийн аюулыг харьцангуй хохирол багатай давах, малчин хүний амьдрах хэвийн нөхцөл бий болгохын тулд өвлийн хахир хатуу хэдэн сард харьцангуй суурин, хагас суурин байдлаар амьдрах нөхцлийг бий болгох нь нэн тэргүүний асуудал болж байна.

• Малчин хүн зөвхөн мал маллагааг дагнах биш мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний анхан шатны боловсруулалт хийж бүтээгдэхүүнээ үнэд хүргэх, өвөлжөө хаваржааныхаа ойролцоо малын тэжээл, төмс, хүнсний ногоо тариалах, малын үржлийн болон мал эмнэлгийн анхан шатны мэдлэгтэй

малчин-үйлдвэрлэгч, малчин-мэргэжилтэн байх шаардлагатай. Малчид өвлийн улиралд малаа тэжээх, бүтээгдэхүүнээ боловсруулах, тэжээл, ногоо тарих бэлтгэл зэрэг ажлын хажуугаар телевиз, радио, сонин хэвлэлээс мэдээлэл авах, богино хэмжээний сургалт явуулж, тал бүрийн мэдлэг эзэмших ажлыг сууриндуу байх өвлийн 3-4 сарын хугацаанд зохион байгуулж байх шаардлагатай. Ингээд нэг хэсэг нь хавар, зун, намрын улиралд соргог бэлчээрт малаа даган нүүдэллэж тарга хүч авхуулах, ноос, үс, сааль сүүгээ базаах ажлаа гүйцэтгэж байгаад өвөл эргэж ирдэг. Нөгөө үлдсэн хэсэг нь малын тэжээл төмс, хүнсний ногоо тарих хадлан өвсөө бэлтгэх, түүхий эдээ боловсруулах ажлаа хийдэг тийм ажил амьдралын хэв загварт шилжих шаардлагатай. Ийм нөхцөлд бэлчээрийн болон хагас суурин хосолсон мал аж ахуй эрхлэх арга хэлбэр бий болно. Дулааны улиралд малаа бэлчээрээрmallаж буй үедээ ч гэсэн малчид гэрэл, цахилгаан, холбоо харилцаагаар хангагдсан байх ёстой. Бэлчээрийн мал аж ахуйгаас гадна томоохон хот, суурингийн ойролцоо сүү, мах үйлдвэрлэх болон гахай, шувуу эрхэлсэн эрчимжсэн чиглэлээр аж ахуй хөгжүүлэх нь зүйтэй.

• Мал аж ахуйд дээрх чиглэлийг хэрэгжүүлэхэд өмчийн эзэн малчид, тэдэнтэй хамтарч ажилладаг хувийн хэвшлийнхэн, бизнесменүүдийн хамтын ажиллагаа чухал. Үүний хамт төрийн зүгээс хууль эрх зүй, зээл татвар, санхүүгийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай. Үүнийг төр бодлогоороо зохицуулах нь зүйтэй. Дээрх асуудлыг

шийдэхэд чиглэгдсэн томоохон төсөл хөтөлбөрийг ч хэрэгжүүлж болох юм.

• Мал аж ахуйг хөгжүүлэхэд баримтлах нэг гол чиглэл нь цаг уурын огцом өөрчлөлт, бэлчээрийн даац, хүрэлцээ, өвөлжилт болон бусад хүчин зүйлүүдийг бодолцон малын тооны өсөлтөд хязгаартай байх (30-35) бодлого баримталж, малын чанар, ашиг шимиийг нэмэгдүүлэх, нутгийн шилмэл омгийг өсгөж үржүүлэх бодлого барих. Мал аж ахуйн үйлдвэрлэлд ялангуяа үржлийн эмнэлгийн үйлчилгээнд шинжлэх ухаан техникийн сүүлийн үеийн ололт, био, нано технологийг нэвтрүүлэх тусгай хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх

• Мал аж ахуйг эрхлэх аж ахуйн хэлбэрийн хувьд өрхийн аж ахуйгаас гадна сүүлийн үед нэлээд өргөжих хандлагатай байгаа бүлэг, хоршоо, фермерийн аж ахуйг төрөөс дэмжих бодлого барьж төсөл хөтөлбөрт өргөн хамруулах.

• Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг малчдаас зах зээлийн дундаж үнээр худалдан авдаг. Малчдад хэрэгцээт бараа таваарыг олж нийлүүлдэг сүлжээг бий болгох. Энд малчидтай холбоотой ажилладаг улсын үйлдвэр, хувийн хэвшлийнхийг өргөн оролцуулахад чиглэгдсэн эдийн засгийн

урамшлын бодлогыг төрөөс авч хэрэгжүүлэх.

• Малын гаралтай түүхий эдийг боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүдийг малчдад ойртуулж, орон нутагт зохистой байршуулах, энд өмчийн эзэн малчин, түүхий эдийг худалдан авдаг үйлдвэр, аж ахуй нэгж, төр гурвын хамтын чармайлт, харилцан дэмжлэг шаардлагатай. Энэ арга хэмжээнд чиглэгдсэн тусгай төсөл ч хэрэгжүүлж болох юм.

• Зах зээлийн хэрэгцээ, шаардлага, хэтийн төлөвийг харгалзан зонхилон үржүүлэх малын төрөл, ашиг шимиийн чиглэлийг зөв сонгох, бусчлэн хөгжүүлэх. Ялангуяа махны чиглэлийн үүлдрийг түлхүү үржүүлэх ажлыг зохион байгуулах.

• Үүлдэр сайжруулах үржлийн бодлогыг зөв томъёолж хэрэгжүүлэх, шинэ үүлдэр, удам, хэвшил бий болгох, үржлийн цөм сүргийг бүрдүүлж хамгаалах чиглэлээр эрдэм шинжилгээний байгууллага, малын удмын сангийн үндэсний төв, үржлийн болон цөм сүргийн төвийн материаллаг баазыг бэхжүүлэх, үр хөврөл, өндгөн эс зэрэг үржлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, ашиглах, малын хүйс жолоодох зэрэг шинэ, шинэ чиглэлүүдийг боловсруулж арилжааны хэлбэрт оруулж нэвтрүүлэх.

## ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН АСУУДАЛ

### 1. ТАРИАЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

**М**онгол улсын газар тариалан бие даасан салбар болон хөгжиж, жилд 650-900 мянган тонн ургац хураан авч, улс орныхоо дотоод хэрэгцээг бүрэн хангаж, гадаадад тариа, ногоо экспортолж байсан түүх саяхан.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед бүх зүйл улсаас төвлөрсөн журмаар тариалан эрхлэгчдэд улсаас тогтоосон үнээр худалдан хангаж байсан нь тогтвортой ургац авахад нөлөөлж байсан боловч хамгийн гол нь тариалан эрхлэгч аж ахуй нэгж, тариаланчид маань тариалангийн үйлдвэрлэлийг явуулах техник, технологийн горимыг нарийн чанд сахиж ёсчлон мөрдөж, байсан нь тогтвортой ургац авах үндсэн нөхцөл болж байсан юм.

1970-аад оноос хөрсийг эргүүлж хагалдаг системийг бүрэн халж, зурvasлан тариалах, хөрсийг хавж боловсруулан тариалах шинэ технологийг бүрэн хэрэглэж, эрчимтэй технологи иж бүрэн нэвтэрсний үр дүнд 1970-аад оны сүүлч 1980-аад онд бол газар тариалангийн салбар бүхэлдээ эрчимтэй хөгжлийн замд орсон үе байлаа. Гэвч 1990-ээд оноос газар тариаланд эрчимтэй нэвтэрч байсан техник, технологи аажим аажмаар алдагдаж газар тариаланг зах зээлд шилжүүлэх бодлого тэр бүр оновчтой бус байсан зэрэг объектив, субъектив олон хүчин зүйлээс шалтгаалж энэ салбар хүрсэн төвшингөөсөө ухраад зогсоогүй, бүр уналтын байдалд орж, 2005 онд Монгол Улс түүхэндээ хамгийн бага ургац (70,0 гаруйхан мянган тонн) авч газар тариалан Монголд сэргэх үү? мөхөх үү? гэдэгт тулсан юм.

#### Тариалсан талбай (мянган. га)

Хүснэгт № 10										
Үзүүлэлт		1975	1985	1986	1987	1988	1990	1995	2000	2005
Нийт тариалсан талбай		509.9	789.6	803.7	800.2	828.4	787.7	372.6	209.3	189.6
Үзүүлэлт	Үр тариа	437.1	636.2	629.7	622.4	641.6	640.1	356.5	194.7	159.1
	Төмс	4.3	10.3	11.2	12.4	13.1	12.1	6.2	7.9	9.8
	Хүнсний ногоо	1.9	3.3	3.8	4.0	4.4	3.6	3.2	5.4	5.9

Ургац хураалт (мян.төг)

*Хүснэгт № 11*

	<b>1975</b>	<b>1985</b>	<b>1986</b>	<b>1987</b>	<b>1988</b>	<b>1990</b>	<b>1995</b>	<b>2000</b>	<b>2005</b>
Үр тариа	482.5	889.4	869.0	689.4	814.3	718.4	261.4	142.1	75.5
Улаанбуудай	365.7	692.0	663.7	543.3	672.2	596.2	256.7	169.5	142.1
Овьёс	49.4	52.5	49.3	37.8	37.4				
Арвай	64.1	132.5	146.0	102.0	100.2				
Төмс	40.7	115.0	132.8	147.0	103.0	131.1	52.0	58.9	82.8
Хүнсний ногоо	21.2	41.3	46.4	48.0	58.4	41.7	27.3	44.0	64.2

Нэг га-гийн ургац (цн/га)

*Хүснэгт № 12*

	<b>1975</b>	<b>1985</b>	<b>1986</b>	<b>1987</b>	<b>1988</b>	<b>1990</b>	<b>1995</b>	<b>2000</b>	<b>2005</b>
Үр тариа	11.0	14.0	13.8	11.1	12.7	11.0	7.3	7.3	4.7
Улаанбуудай	11.6	14.3	14.2	11.6	13.7	11.2	7.4	7.2	4.8
Овьёс	8.4	12.0	10.0	8.1	8.8	10.4	0.6	2.1	6.9
Төмс	94.4	111.8	119.0	118.8	78.6	107.7	83.5	74.7	84.8
Хүнсний ногоо	108.0	138.9	122.1	119.3	135.1	115.8	85.3	81.5	109.0

Өнгөрсөн жилүүдэд төр засаг, салбарын яам газар тариалангийн салбарыг бас ч огт хараанаасаа гаргаагүй хэсэгчилсэн арга хэмжээг авсаар байсан болон тариаланч хамт олны сэтгэл зүтгэлийн үр дүнд энэ салбар өдийг хүртэл амьсгалсаар байна.

2006 онд Хүнс, Хөдөө аж ахуйн яамны санаачлагаар тариалангийн оролцоотойгоор газар тариалангийн салбарт техник,

технологийн шинэчлэлт хийх цогц хөтөлбөр боловсруулж, өргөн бүрэлдэхүүнээр хэлэлцэн баталж, мөрдөн, бодлогын чанартай зарим арга хэмжээ авч байгаа нь газар тариалан сэргэн хөгжихийн найдвар төрүүлж байна. Тариаланг эрчимтэй эрхэлж, хөгжүүлэх нь зөвхөн тариа, ногоогоор дотоодын хүнсний хэрэгцээг хангах төдий биш хамгийн гол нь мал аж ахуйг эрчимтэй хөгжүүлэх нөхчлийг хангах суурь үндэс болно. Таримал тэжээлийн найдвартай

бат баазгүйгээр мал аж ахуйг эрчимжүүлэх зорилт хэдийд ч хэрэгжихгүй, зудын аюулаас хэзээ ч гарахгүй гэдгийг бүх төвшинд сайн ойлгож Монгол улсад газар тариалан эрхлэн хөгжүүлэх бодлогыг явуулах учиртай.

## 2. ГАЗАР ТАРИАЛАН СЭРГЭЭН ХӨГЖҮҮЛЭХЭД ЗАЙЛШГҮЙ АНХАРАХ ЗАРИМ АСУУДАЛ


**2.1.** Монголд газар тариалан хөгжүүлэх ямар шаардлага байгаа вэ? Тэр 300 мянган тонн гурилыг чинь гаднаас зөөж байвал ясан юм бэ? гэсэн ойлголт зарим хүмүүст байдаг. Энэ бол дараа гарах нийгэм эдийн засгийн үр дагаврыг тооцоогүй дэндүү гэнэн хэрэг. Хоёр их гүрний дунд орших, geopolitikiйн онцгой байршилтай манай орны хувьд өнөөдөр хямд амархан олдоцтой байгаа тэр гурил будаа маргааш ямар үнэтэй болох вэ? гэдгийг хэн ч таахад бэрх, ер нь огт олдохгүй болохыг ч

үгүйсгэх аргагүй юм. Гурил будаагаа гаднаас зөөдөг юм гэхэд 1 сая нэг зуун мянган тонн тэжээлийн нэгчтэй тэнцэх тэжээлээ бас зөөх үү?


Дэлхийн үр тарианы хувь заяаг шийддэг томоохон улсуудын байдал, эрдэмтдийн судалгаанаас үзэхэд дэлхийн улаан буудайн баланс сүүлийн жилүүдэд тийм ч сайнгүй байгаа, цаашид ч нэг их огцом сайжрах хандлага ажиглагдахгүй байна. Эд бүгдийг эргэцүүлэн үзэхэд эрсдэлтэй ч гэсэн тариалангаа авч явахаас өөр аргагүй.


**2.2.** Монголын хүн амын хүнсний хэрэглээний бүтцийг үзэхэд хот, хөдөө хаана ч мах, дараа нь гурил, гурилан бүтээгдэхүүн орж байна. Манай улсын нэг өрхийн хүнсний бүтээгдэхүүний хэрэглээний зарлагын бүтцэд гурил нийслэл, аймгийн төвд 27-38 хувь, хөдөө сумын төвд 60-53 хувь байна.

Манай орны нэг өрхийн хүнсний бүтээгдэхүүний зарлагын бүтэц (хувиар) Хөдөө



Сумын төв





Эдгээр үзүүлэлтээс харахад гурил бол монголчуудын хувьд махны дараа орох онцгой хэрэглээ болох нь тодорхой байна.

### 2.3 Газар тариалангийн салбарын бүтцийн өөрчлөлт хийж, газрыг өмчлөх, үйлдвэр эрхлэх аж ахуйн хэлбэрийг сонгож авахдаа:

- Монголд тариалан эрхлэх түүхэн өв уламжлал хомс, хүн ам цөөн, таруу сийрэг байршилтай, дэд бүтэц харьцангуй сул хөгжсөн, зах зээлийн багтаамж хязгаарлагдмал
- Монголын нийгмийн бүтцэд өвлөх өмч хөрөнгөтэй тариачны хэсэг байгаагүй, харин өнөөгийн зах зээлийн нөхцөлд тэр нь шинээр үүсэн бүрэлдэж эхэлж байгаа
- Тариалангийн талбай бүрийн хөрсний үргжил шим, цаг уурын нөхцөл, ургац өгөх чадавхи өөр хоорондоо эрс ялгаатай зэрэг хүчин зүйлийг онцлон анхаарч салбарын хөгжлийн хэтийн хандлагыг урьдчилан харсан байх шаардлагатай

- Эх орны хөрсөнд ургуулж буй тариалангийн бүтээгдэхүүн экологийн хувьд харьцангуй цэвэр хүнсний аюулгүй байдлыг хангасан байdag.

### 3. ТАРИАЛАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ТОГТВОРТОЙ ХӨГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ

Монгол улсын хүн амын жилийн дундаж өсөлт, гурил, төмс, хүнсний ногоо хэрэглээний физиологийн дундач нормыг үндэслэн үзэхэд ойрын 10 жилд жил бүр гурил 260-300 мянган тонн, төмс хүнсний ногоо 180-220 мянган тонн үйлдвэрлэж байх шаардлагатай. Газар тариалан эрхэлж байгаа өнөөгийн төвшинд энэ хэрэгцээг хангах боломжгүй бөгөөд тариалах талбайг 2 дахин, га-гаас авах ургацыг 50-аас доошгүй хувиар нэмэгдүүлж, техник, технологи, бүтэц зохион байгуулалтын цогц арга хэмжээг авч байж шийдвэрлэнэ. Энэ зорилгоор:

3.1. Газар тариалан эрхлэх бодлогыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нягт уялдуулан явуулж бүс бүрд тариалан эрхлэх онцлогт нийцүүлэн хөрөнгө оруулалт, зээл санхүүгийн ялгавартай бодлого явуулах.

Сэлэнгэ, Төв, Булган, Хэнтий аймгийг таваарын үр тариа, төмс, хүнсний ногоо, техникийн ургамал, Хөвсгөл, Өвөрхангай, Дорнот, Увс, Архангай аймагт таваарын үр тариа, малын тэжээл, төмс хүнсний ногоо, Баян-Өлгий, Завхан, Ховд, Баянхонгор, Говь-Алтай, Өмнөговь, Дорноговь, Дундговь, Сүхбаатар аймагт малын тэжээл, төмс, хүнсний ногоо тариалах чиглэл байж болох юм. Хувийн хэвслийн аж ахуй нэгж, иргэд дээрх чиглэлийн дагуу үйлдвэрлэл эрхлэх сонголтоо хийх боломжтой.

3.2. Газар тариалангийн талаар баримтлах гол бодлого бол тариалах **талбайн хэмжээг нэг их нэмэхгүй, нэгжээс авах ургацынг нэмэгдүүлэхэд чиглэгдэх учиртай**. Юуны өмнө усалгаатай тариаланг богино хугацаанд эрс нэмэгдүүлэх замаар газар тариалангийн асуудлыг шийдвэрлэж чадна.

**Ойрын 15 жилд усалгаатай тариаланг 120,0 мянган га-д хүргэх зорилт тавьж, эхний 10 жилд хуучин ашиглагдаж байсан ба ашиглахад бэлтгэж байсан инженерийн болон энгийн хийцтэй 80 орчим мянган га газрыг ашиглалтанд оруулж, энэ хугацаанд хайгуул судалгаа хийх замаар дараа 5 жилд 40 мянган га усалгаатай талбайг ашиглалтанд оруулах**

зорилт тавьж хэрэгжүүлэх. Энэ бол тийм ч амаргүй бөгөөд ихээхэн хүч хөрөнгө шаардсан шахуу, том зорилт. Үүнийг барьж авч нэгэн далаильтаар шийдэхээс өөр аргагүй.

Уг зорилтыг шийдвэрлэж байж газар тариалангийн үйлдвэрлэл бүрэн сэргэж, энэ салбарынхан улсын гар харахгүйгээр бие даан ажиллах бүрэн боломжтой болно. **120,0 мянган га усалгаатай талбайгаас дунджаар тооцоход 480,0 мянган тонн ургац авна. Үнээс гадна 200 орчим мянган га усалгаагүй тариалж 160 орчим мянган тонн ургац авна гэж бодвол ойрын 20 жилдээ л манай улсын хүнсний үйлдвэрүүдийн болон малын тэжээлийн хувьд нэг их дутагдалд орохгүй байх нөхцөл бүрдэнэ. Ийм учраас гадаад дотоодын зээл, санхүүгийн нөөцөөс энэ арга хэмжээнд хаяхаас өөр аргагүй. Хамгийн наад зах нь услалтын систем сэргээхэд улсын төсвөөс өгч буй хөрөнгийг 5 дахин нэмэх шаардлагатай.**

3.3. Газрын шинэтгэл, газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах асуудал шийдэгдэж, газрын болон газар өмчлөх тухай хуулиуд шинэчлэгдэж гарсан нь иргэд аж ахуй нэгжүүдэд газартай харьцаж ашиглах шинэ боломж нээгдэн, ялангуяа сүүлийн жилүүдэд урьд тариалан эрхэлж байгаагүй аж ахуй нэгж, иргэд газар тариалан эрхлэх сонирхлыг бий болгож байгааг **төрөөс зориуд дэмжиж татвар зээлийн бодлогоор урамшуулах нь** газар тариалан сэргээн хөгжихөд чухал түлхэц болно. Мөн гадаадын хөрөнгө оруулагчид, бизнеменүүд

манай улсад дотоодын байгууллагуудтай хамтран буюу дангаараа газар эзэмшиж тариалан эрхлэх сонирхол байдгийг ч харгалзан үзэж найрсаг боломж тавьж, хөхүүлэн дэмжих бодлого явуулах нь зүйтэй. Тэдэнд газраа *түрээслүүлэх буюу бусад хэлбэрээр ашиглуулж, манайд тариалдаг уламжлалт таримлаас гадна гурвалжин будаа, рапс, шар буурицааг зэрэг хүнс тэжээлийн ондөр чанартай таримал тариалж, экспортод гаргах, дайвар бүтээгдэхүүнээр нь* малын тэжээл үйлдвэрлэх боломжийг ч өргөн ашиглах нь зүйтэй.

3.4. Техникийн шинэчлэл явуулахад баримтлах гол зарчим бол импортолж байгаа техникийн үзүүлэлт нь монгол орны хөрс, цаг уурын нөхцөлд зохицсон, тариалангийн технологийн шаардлагыг бүрэн хангасан байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлдэггүй, нэг явалтаар олон үйлдэл гүйцэтгэх боломжтой, материал, энергий, түлш шатахуун хэмнэлттэй зарцуулдаг шаардлагыг хангасан байвал зохино. Техникийн шинэчлэлийг явуулахдаа доорхи зүйлийг анхаарах нь зүйтэй гэж үзнэ. Үүнд:

- Хавж элдэншүүлэх, цомтгосон элдэншүүлэг, тэг элдэншүүлэг зэрэг дэвшилтэт технологийн шаардлагад тохирох хөрс хамгааллын машин техникийг улс орны болон тариалан эрхлэгч аж ахуйн нэгжийн өнөөгийн эдийн засгийн хүч, чадал эзэмшиж дадаж заншсан байдал зэргийг харгалзан эхний үед Оросын Холбооны Улсаас голчлон авах, цаашид Канад, АНУ, ХБНГУ, Япон зэрэг дэлхийн дээд ангиллын ХАА-н техник үйлдвэрлэдэг

орнуудаас сонголт хийж авах чиглэл баримтлах

- Худалдаж авах техникийн төрлөөр тендер зарлаж шалгарсан компаниудад тэр төрлийн техникийн дараагийн нийлүүлэлт, засвар үйлчилгээ үзүүлдэг урамшлын арга хэлбэрийг ч хэрэглэж болох юм,

- Гадаад орны пүүс компаниас машин техник худалдан аваахдаа засвар үйлчилгээ, сэлбэгийн асуудлыг хамтад нь шийдвэрлэж тэдгээр пүүс компанийн нэрийн болон хамтарсан сервис, диллерийн тогтолцоог бий болгох

- ХАА-н техникийн түргэн солигддог, эрэлт хэрэгцээ ихтэй сэлбэг хэрэгсэл болон зарим машин техникийн дотооддоо хийх, угсралт, хамтарсан жижиг үйлдвэр байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх,

- Техникийн бодлогын нэг салшгүй хэсэг бол боловсон хүчин, ялангуяа механикжуулагчдыг сургаж бэлтгэх, давтан сургах явдал юм. Энэ ажил сүүлийн жилүүдэд бараг орхигдсоноос одоо ажиллаж байгаа техникчдийн халааг авах залгамж үе тасалдах, тариаланчид үр хүүхдээ үе залгамжуулах, мэргэжил эзэмшүүлэх боломж алдагдахад хүрч байна. Өнөөдөр зөвхөн техник эзэмшдэг явцуу утгаар биш, технологи, менежмент, маркtingийн өргөн мэдлэг бүхий мэргэжилтэн, тариаланчдыг бэлтгэх явдал тулгамдсан асуудал болж байна. Энэ зорилгоор тариалангийн аж ахуйд ажиллаж байгаа удирдах ажилтан, мэргэжилтэн, ХААИС-ийн төгсөх ангийн оюутнуудаас тодорхой тооны хүмүүсийг шалгаруулж, тариалан өндөр хөгжсөн орнуудын фермерийн аж ахуйд

тодорхой хугацаагаар жил бүр явуулж, ажилчны журмаар ажиллуулан тариаланч, менежер бэлтгэх ажлыг зохион байгуулж болох юм. Мөн дотооддоо байнгын сургалт, курс, семинар зохион байгуулж хүмүүсийг зах зээлийн үеийн аж ахуйг удирдах арга ухаанд сургаж, тэднийг сэтгэл зүйн хувьд бэлтгэх явдал чухал байна.

### 3.5. Технологийн бодлогын хувьд:

- Газар тариаланг өөрийгөө нөхөн төлжүүлэх чадвар бүхий хөрс хамгаалах эрчимжсэн технологиор явуулж нэгжийн ургацыг ойрын үед мэдэгдэхүйц нэмэгдүүлэх. Манай газар тариаланд үр ашгаа нэгэнт өгч өргөн хэрэглэгдэж байсан хөрс хамгаалах технологийг сэргээн хөрсийг хавж боловсруулах, уриншийн зарим механик боловсруулалтыг гербицидээр орлуулах, уринш таримлыг зурvasлан байрлуулах, сүрлийг талбайд хэрчиж цацах зэрэг арга хэмжээг өргөжүүлэх

- Бухаар тариаланд цулгүй уриншийн эзлэх хувийг багасган таримлын тоог олшруулах, тэжээлийн ургамлыг оруулах замаар эргэлтийн хугацааг уртасгах нь хөрсний үржил шимиийн бууралтыг сааруулах гол арга хэмжээ юм. Бүс нутгийн онцлог, жилийн цаг агаарын нөхцлийг харгалzan тарималт ба ногоон бордоот уриншийг ямар нэгэн хэмжээгээр хэрэглэх нь тодорхой ач холбогдолтой гэж үзэж байна.

3.6. Газар тариалангийн даатгалын тухай хуулийг цаг агаарын өөрчлөгджэх байгаа нөхцөлтэй уялдуулан өөрчлөн, шинэчлэх. **Эсвэл газар тариалангийн даатгалын тухай хуулиг олон**

*улсын байгууллагын дэмжлэг тусlamжтайгаар цоо шинээр боловсруулж гаргах. Даатгалын зөв тогтолцоо бий болгох нь тариаланг сэргээн хөгжүүлэх чухал хөшүүрэг болно.*

3.7. Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны байгууллага зах зээлд нэн удаан хөл тавьж байна. Төсөл нэрийн дор улсын төсвөөс хэдэн төгрөг авч түүнийгээ “мөлжиж” суудаг аргаасаа салах цаг болжээ. Улсаас ч шинжлэх ухааны байгууллагыг төсөл шалгаруулах нэрийн дор санхүүжүүлдэг аргаа өөрчилж, зах зээлийн жаяг дэгд нийцсэн аргад нэн яаралтай шилжих шаардлагатай байна. Юуны урьд эрдэм шинжилгээний нэгж байгууллага болон **эрдэмтэд аж ахуй нэгж байгууллагатай хоёрлосон, гуравласан гэрээ байгуулах үндсэн дээр үйлдвэрлэлийн нөхцөлд судалгааны ажлаа явуулж, үр дүн, ашиг орлого, мөн хариуцлагага ч хуваалцдаг үйл ажиллагааны хэлбэрт шилжих хэрэгтэй байна.** Америк, Канад зэрэг оронд ийм хэлбэр (фермерүүдтэй шууд ажилладаг) их байдаг юм билээ.

3.8. Шинжлэх ухаантай холбоотой өөр нэг санал нь хөдөө аж ахуйн шинжлэх ухааны байгууллага түүний дотор ургамал газар тариалангийн эрдэм шинжилгээний байгууллагуудыг үйлдвэрлэлтэй нягт холбох чиглэлээр **Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны академи болгон нэгтгэх замаар бүтцийн өөрчлөлт хийж** шинжлэх ухаан үйлдвэрлэлийн холбоог ойртуулж өгөөжийг дээшлүүлэх.

3.9. Тариалангийн үйлдвэрлэлийн техник, технологийн бодлогыг хэрэгжүүлэх, хяналт тавих болон бүтээгдэхүүний борлуулалт, экспорт, импортыг зах зээлийн эрэлт шаардлагад нийцүүлэн үл ажиллагаагаа явуулдаг бүтэц зохион байгуулалтын цоо шинэ тогтолцоог бий болгох. Энэ зорилгоор ХХААЯ-ны “Буудайн сан”-г яамны бүтцээс гаргаж өргөжүүлэн төрийн өмчийн оролцоотой хувьцаат компани, юмуу эсвэл корпорацийн хэлбэрээр (Канадын Wheat Board-ын жижигрүүлсэн хэлбэр) зохион байгуулах. Уг шинэ бүтэц нь техник, үр бордоо, гербицид, усалгааны техник импортоор оруулах болон тариалангийн бүтээгдэхүүнийг худалдан авч борлуулах, тодорхой хүрээнд хөрөнгө оруулалт санхүүжилт хийх зэрэг өргөн хүрээтэй асуудлыг хариуцдаг төрийн болон хувийн хэвшлийн өмч хамтарсан байгууллага байна.

Энэ асуудлыг шийдвэл өнөөгийн тулгарсан олон асуудал шийдлээ олох зам нээгдэнэ.

4. Улс орон зах зээлд шилжээд, төрийн оролцоог аль болох багасгах зах зээлийн эдийн засгийн үзэл номлолоор явж байхад энэ нөхөр төрийн оролцоо, төр засгаас авах арга хэмжээ гэж яриад байгаа нь ямар учиртай юм бэ? гэж эргэлзэх юмуу тавьсан асуудалд онцын ач холбогдол өгөхгүй байх хүмүүс байхыг ч би үгүйсгэхгүй. Миний хувьд зах зээлийн эдийн засгийн онолын загалмайлсан эцэг, их сэтгэгч Адам Смит болон түүний залгамжлагч эрдэмтдийг хүндэтгэн биширч, хүлээн зөвшөөрдөг ч манай орны нөхцөл байдал ялангуяа салбарын онцлогийг бодолцон, орон зайд, цаг хугацааны хувьд төрийн оролцоо нэг хэсэгтэй байх нь зүйтэй гэж үзсэнээ хэлье.

## **“МОНГОЛ УЛСЫН ХӨДӨӨ, ХӨДӨӨ АЖ АХУЙН ХӨГЖЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ” СЭДЭВТ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ТЭМДЭГЛЭЛ**

**M**онгол Улсын Ерөнхий сайд асан, Шинжлэх Ухааны Академийн гишүүн, доктор, гавьяат агрономич Ш.Гунгаадоржийн “Монгол Улсын хөдөө, хөдөө аж ахуйн хөгжлийн зарим асуудал” сэдэвт хэлэлцүүлэг 2007 оны зургадугаар сарын 28-нд ННФ-ын хурлын танхимд боллоо. Хэлэлцүүлгийг нээж ННФ-ын гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал үг хэлж, хэлэлцүүлгийн дараа оролцогчид санал хүсэлтээ хэлж, илтгэгчид асуулт тавилаа.

**Б.Минжигдорж /Мал үргүүлэгчдийн холбоо/**  
Төрийн оролцоо гэхээр их дургүйцэж хүлээж авах юм. Зохицуулалтыг нь хэлж байна уу, эсвэл, дэмжлэг туслалцааг нь хэлээд байна уу. Ер нь төрийн оролцоо гэдгийг юу гэж ойлгох вэ. Хуучин системд чи тариагаа тарь, чи ногоогоо хураа гэж заадаг байлаа. Үүнийг л төрийн оролцоо гэж ойлгож байсан байх. Хөдөөг хөгжүүлэхэд газар их чухал. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн гол тулгуур нь газар байдаг. Үндсэн хуульд Монгол улсын иргэн газраа өмчлүүлж болно гэж заасан байгаа.

Тэгээд газраа авах гэхээр өгдөггүй. Жишээ нь, Дорж гуай 480 га газар аваад 100 үнээ маллая гэтэл газраа авч болдоггүй. Ийм байхад хөгжлийн асуудлыг яаж шийдэх юм бэ. Бусад оронд энэ ажил эхэлчихсэн юм биш үү.

Сүүлийн үед монголчууд ашигт малтмалаараа сайхан амьдарна гэж ярьж байна. Энэ нь үнэн хэрэг дээрээ хөдөө аж ахуйн ач холбогдлыг бууруулаад байгаа юм. Статистик мэдээгээр ДНБ-ий 21 хувийг хөдөө аж ахуйн салбар, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний 80 хувийг мал аж ахуй үйлдвэрлэдэг нь харагддаг. Хөдөө аж ахуйн салбар хэдий хүртэл явах юм бэ. 1960 оны эцэс, 1970 оны эхээр Эрдэнэтийн үйлдвэрийг ашиглалтад орвол монголчууд 100 жил ажил хийхгүйгээр амьдарна гэсэн лекц уншиж байсан. Өнөөдрийн алтны уурхай 10 жилийн дараа хөндий нүх л үлдэнэ шүү дээ. Харин хөдөө аж ахуй хэвээрээ байна. Үүнийг юу гэж ойлгох вэ?

**Ш.Гунгаадорж /Монгол Улсын Ерөнхий сайд асан, Шинжлэх Ухааны Академийн гишүүн, доктор, гавьяат агрономич/**



Төрийн оролцоог байхгүй болгох, олон нийтэд эрх чөлөөг нь олгох гэсэн зах зээлийн сонгомол онол бий л дээ. Манайхны нэг хэсэг нь төрийн оролцоог байхгүй болгоё гэдэг. Төрийн оролцоо гэдэг нь хуучин тогтолцооны үеийн оролцоо биш юм. Тэр үед төр оролцоггүй юм гэж байгаагүй. Гэхдээ өнөөдрийн бидний будилж яваа үед төр бодлогоороо оролцох ёстой юм. Жишээ нь, хөдөөгийн малчин хүнд 70-100 жилийн хугацаагаар бэлчээр эзэмших нөхцлийг бүрдүүлэх, хөдөөд зах зээлийн орчныг бүрдүүлж өгөх, мөн эдийн засгийн урамшуулал буюу зээл, татварын бодлого гэсэн хэлбэрээр л явна. Харин төр очиж үйлдвэр барьж өгч, хашааг нь барьж өгөх гэдэг бол буруу юм. Манай хөдөөнийхөн зах зээлийн мэдрэмж ойлголт муутай учраас юм болгон дээр төр мөнгө өгөх ёстой гэсэн сэтгэлгээгээр ханддаг. Ойлголтын зөрүү юм. Зах зээлийн орчныг зөвхөн материаллаг талаас нь биш, бас сэтгэл зүйн хувьд ч бий болгох хэрэгтэй.

1990 онд би засаг тэргүүлж байх үед мөрийн хөтөлбөртөө төрийн зохицуулалттай зах зээл гэж тусгахаар ярьж байсан юм. Манайх шиг оронд төрийн зохицуулалт нь эхний хэдэн жилдээ байя, тэгээд аяндаа төрийн зохицуулалт шаардлагагүй болно гэж үзэж байсан л даа. Гэтэл эсэргүүцээд тэр үгийг нь хэрэглээгүй. Өнөөдөр хөдөө аж ахуй ингэж дор орчихоод байхад, 800 мянган тонн тариа авдаг байсан нь 100 000 хүрэхгүй болчихоод байхад төр бодлогоороо түлхүүр оролцох ёстой.

Газрын асуудал дээр санал нэг байна. Газрын тухай хуульд өөрчлөлт оруулахаар Засгийн

газраар хэлэлцээд одоо УИХ-аар орох гэж байгаа. Хуулийг өөрчлөн батлахад дутуу орхисон юм бий. Ялангуяа бэлчээрийн асуудлыг ярьсаар байгаад яаж ч чадалгүй орхисон юм. Өнөөдөр малчдыг зах зээлд оруулах бодлого хэрэгжээд эхлэхээр бэлчээрийн асуудал нь нийтийн эзэмшил байх аргагүй болчихож байгаа юм. Тэгэхээр бэлчээрийг яаж эзэмшүүлэх вэ. 0.07 га газрыг Монгол Улсын бүх иргэнд өгч байгаа. Төв суурин газарт өмчилнө гэж заасан. Хөдөөгүүр явахаар малчид хашаа хорооныхоо газрыг авч байшин барья, энд хиамны цех байгуульяа гэхээр энэ чинь болохгүй ээ, төв суурин газар гэдэг тухай ярьдаг. Би сумын төв дээр очиж энэ газрыг аваад яах юм гээд л зөрчилдэж байгаа юм. Энэ мэтчилэн газрын хуульд оруулах өөрчлөлт бий. Үүнийг УИХ-ын гишүүд анхаарах биз ээ. Таны хэлж буй зүйлүүд газрын тухай хуульд тусгагдах байх аа.

Нэгийг нь нөгөөгөөр унагаж болохгүй. Ашигт малтмалаа ч ашиглах ёстой, хөдөө аж ахуйгаа ч хөгжүүлэх ёстой. Ер нь хөдөө аж ахуйн салбар энэ дуулиан дотор цохигдож байгаа нь үнэн. Хөдөөгийн хөгжлийн бодлого орхигдоод байгаа учраас хот, хөдөөгийн ялгаа их болчихоод байна шүү дээ. Ийм их баялаг байна. Ашигт малтмалыг ашиглах ёстой юу гэвэл ашиглах л ёстой. Гэхдээ замбараатай, ард түмэндээ унацтай байх чиглэлээр хууль эрх зүйн акт нь гарах ёстой юм.

**Лхагважав /”Урбанек” компани/**  
Би малчдыг хоёр янзаар ойлгодог. 1959 он хүртэл дээр үеийн уламжлалт малчид байсан. Одоо байхгүй. Яагаад гэвэл малыг нь өмчилсөн. То ван гуай, зохиолын баатар

Итгэлт баян бол тэр үеийн үр дүн юм. 1959-1990 он хүртэл хариуцлагатай малчид гэж гарч ирсэн. Яагаад гэвэл тэд өмчгүй, улсын өмчийг хариуцлагатайгаар маллаж байсан. Энэ үед Очирбат, Намхайнямбуу зэрэг шилдэг малчид гарч ирсэн байгаа. 1990 оноос хойш малчид дахин өмчөө авсан. Өмчийн харилцаа зах зээлд орсон.

Сүүлийн 17 жилд бид малчдаа хэт энхрийлээд татварын орчны гадна үлдээчихсэн. Зах зээл бол нягтлан бодох бүртгэл, санхүү маркетинг талаасаа их нарийн тооцоо. Гэтэл малчид татварын гадна орхигдсон учраас зөвхөн тооны хойноос явсаар одоо уламжлалт феодал маягийн малчид гарч ирээд байгаа юм л даа. Төрөөс энэ чиглэлээр сургалт, танин мэдэхүйн ажил хийхгүй байгаа. Өөрөөр хэлбэл, малчдад эдийн засгийн мэдэгдэхүүн буюу өмчтэйгөө харьцах мэдэгдэхүүн суулгаагүйн хар гай юм. Тэд малтайгаа зах зээлийн сэтгэхүйгээр харьцаж чадахгүй байгаа. Тийм учраас малчдаас тодорхой хэмжээний татвар авах ёстой гэж би үзэж байгаа. Татвар авна гэдэг бол өөрсдөө хариуцлагатай болно, тооны хойноос биш чанарын хойноос явна. Манай Иргэний хуулиар малчин хүмүүс адилхан ялтай болчихож байгаа юм. Энэ хууль бол Германы хуулийн хуулбар. Германд мал буюу алдуул мал гэсэн ойлголт байхгүй. Иргэний хуулийн 117-д алдуул малтай холбоотой гурван зүйл байдаг. Малчин хүн хоёр адuu явж байхад мэдэлгүй авч яваад уулын цаана эзэнтэй нь тааралдвал эрүү үүсэх болзол хангагдсан байгаа. Манай эртний хуулиудад алдуул малтай холбоотой асуудлыг маш хүмүүнлэг байдлаар шийдсэн байдаг. Гяндан шоронгийн зарчмаар биш.

Энэ аргуудыг хуучны эрх зүйгээсээ оруулж ирвэл малчдыг алдуул мал олсны төлөө эрүү үүсгэхгүйгээр хүн гэдэг үүднээс нь шийдэх боломжтой юм. Үүнийг харах хэрэгтэй байна.

Татварын орчныг нь дахин бүрдүүлж сэтгэлгээнд нь суулгаж өгөх хэрэгтэй байна. Тэгэхгүй бол малчид маань их хурдан гуйлгачин болох гээд байна. Ганц алга эргүүлэхэд л гуйлгачин болчихоод байдаг.

**Ш.Гунгаадорж /Монгол Улсын Ерөнхий сайд асан, Шинжлэх Ухааны Академийн гишүүн, доктор, гавьяат агрономич/**

17 жил малчнаа хэт энхрийлсэн гэдэгтэй би санал нийлмээргүй байна. Бодлого үгүйлэгдээд байгаа нь үнэн. Татварын асуудал бол өөр зүйл. Өнөөдөр зах зээл гэж юу байна аа. Малчид өөрсдөө бий болгох үүрэгтэй ч төрөөс бодлого дутаж байгаа зүйл бий. Татварт хамруулах асуудал нь түүний нэг хөшүүрэг байж магадгүй.

**Батдэлгэр /ХААИС-ийн багш/**

Хөдөө аж ахуйн техникийн лизингийн хууль гаргана гэж 2-3 жил ярилаа. Ямар шатандаа яваа юм бол. Энэ хууль батлагдах үндэслэл бий ю?

ОХУ руу манай дугуйт трактор гараад дууслаа. Хамгийн сүүлийн үеийн тооцоогоор 5600 дугуйт трактор байсан. 80 хувь нь гараад байна. Одоо гинжит трактор гараад эхэллээ. Манайх машины үйлдвэргүй, тоног төхөөрөмж үйлдвэрлэдэггүй мөртлөө чөлөөтэй гаргаад байдаг. Үүнийг холбогдох байгууллагууд нь мэддэг болов уу. Сүүлийн 15 жилд газар тариалангийн салбарт нийлүүлсэн тусlamжийн тракторын баталгаат засварыг би хариуцаж байгаа. “Кубота”, “Нью

холанд” белорусь, тракторууд тусламжаар орж ирж байна. Сэлбэгийн эргэлтийн сан байгуульяа гэж ХХААЯ-аар олон удаа явсан. УИХ-ын гишүүн, байнгын хорооны гишүүдтэй ч захидаар харьцаж байсан. Техникийн эргэлтийн санг байгуульяа гэхээр дургүйцдэг. Улаанбаатар хотын гудамжаар дүүрэн машин байхад холбогдох газрууд нь сэлбэгийн асуудлыг тавьдаггүй. Тракторын сэлбэг, хөдөө аж ахуйн машины сэлбэгийн эргэлтийн сан байгуулна гэхээр дэмий юм ярьж байна гэдэг. Тансаг хэрэглээ, үйлдвэрлэлийн машин хоёрыг ойлгохгүй байгаа үед бид амьдарч байж болно гэж үү. “Нью холанд”-ын “гүүд ейэр” дугуйг Хятадаас аввяа гэхэд 800 доллар. 50 ширхэгийг аввяа гэхэд 350 доллар гэдэг. Сэлбэгийн сан байгуулах арга хэмжээг төрөөс авч зохицуулбал хамаагүй бага зардлаар эргэлтийн сантай болно.

**Ш.Гунгаадорж /Монгол Улсын Ерөнхий сайд асан, Шинжлэх Ухааны Академийн гишүүн, доктор, гавьяат агрономич/**  
Лизингийн асуудал ихээхэн яригдаж байгаа. Газар тариалангийн салбарыг сэргээн хөгжүүлэхэд лизинг их чухал. Одоогоор эрх зүйн орчин бүрдээгүй байна. Энэ үйлчилгээг нэвтрүүлэхэд хувийн хэвшлийнхэн ч дуртай байгаа болов уу. Мөн лизингийн үйлчилгээ үзүүлье гэсэн гадаад дотоодын компаниуд ч бий байх. Эрх зүйн орчин нь ч бүрдэх байх. Гадагшаа трактор гарч байгаа гэдэг бол их ноцтой асуудал. Сүүлийн үед гинжит тракторууд их хэмжээгээр гарч байна гэсэн. Яаж зохицуулгажд байгаа нь бүү мэд. Төрийн түшээдийн сонорт хүрсэн байдаг болов уу. Засгийн газар, ХХААЯ юу хийж суудаг юм

бэ. Үүнийг байнгын хорооны сонорт хүргэж анхааруулах асуудал байна.

Сэлбэгийн сан гэдэг бол их зөв юм. ХХААЯ-д хамааралтай асуудал. Манайд трактор үйлдвэрлэдэггүй. Ойр зуурын сэлбэгийг эндээ хийх бололцоо бий. Өмнө нь хийж л байсан. Үүнийг анхаарах л ёстой юм.

### Ламжав

Манай сумуудад засаг захиргааны хариуцлага байхгүй, тооцоо бүртгэл их сул. Жишээ нь, малаа яаж тоолж байгаа билээ. Намайг бага байхад кинон дээр гардаг шиг их сайн тоолдог байсан. Зуны сайхан цагаар. Харин одоо таваг дүүрэн мах чануулж, шил архи тавиад эзнээс нь асуугаад л тоолж байна. Малчид хэнээс ч айх юм алга. Засаг дарга байж л байна. Тэднээс үзүүлэх ямар ч дарамт байхгүй. Энэ нь татвартай холбоотой. Татварын бодлого их чухал. Гэтэл УИХ-ын гишүүд малчдыг татвараас чөлөөлнө гэж үргэлж ярьдаг. Дахин сонгогдохын тулд тэднээс айгаад байгаа юм. Малын татвар нэмсэн хууль баталчихвал миний төлөө саналаа өгөхгүй гэж. УИХ-ын гишүүддээ хандаж хэлэхэд хэрэгтэй юмыг цаг үед нь хийчих хэрэгтэй гэж хэлмээр байна. Бас нэг асуудал бий. Малын татварыг сум суманд нь тогтоох эрхийг өгсөн. Нэг суманд татвараа тогтоочихдог. Гэтэл хажуу талын суманд нь бага татвар тогтоохоор малчид бослого гаргаж шахдаг. Тэгэхээр ИТХ бас сонгуулиас айгаад татваргүй болгочихдог. Сумын захиргаа төсөв авсан ч их ядуу. Малын татварыг зохистойгоор тогтоож түүнийг сумандaa зарцуулдаг механизмд шилжих ёстай. Ам булийн тоо энэ тэрээс хамаарах нь мэдээж.

Ямааг цөөлөх шаардлагатай эсэхээ эрдэмтэдтэйгээ ярина биз. Ямааг цөөлөх, тэмээг өсгөх шаардлагатай бол төчнөөн ямаан тутмаас нэг ямаа, төчнөөн тэмээнээс төдөн тэмээ гэсэн ялгавартай татварын хуулийн зохицуулалт хийж болно. Хөдөө мөнгө бага учраас мөнгөөр татвар авахад хэцүү. Мөнгөөр эсвэл биетээр нь өгч болно. Тэр цуглуванс малаа бизнестэй холбож чадахгүй бол ямар сум байх билээ. Татварын хуулийг УИХ баталж өгөх хэрэгтэй. Энэ нь хөдөөгийн малчдыг иргэншихэд маш их тустай. Тэднээс авсан татвараар сургууль, эмнэлгээ ядуурлаас гаргахуйц хэмжээний хөрөнгө цугларах байх гэж бодох юм.

#### **А.Бакей /УИХ-ын гишүүн/**

Хөдөөгийн хөгжил, хөдөө аж ахуйн хөгжил гэдэг бол МУ-ын хөгжлийн хамгийн гол асуудал гэж боддог. МУ-ын хөгжлийн цогц бодлогыг боловсруулж дуусаад УИХ-аар хэлэлцэх шатанд явж байна. Энэ цогц бодлогод хөдөөгийн хөгжлийн бодлого, хөдөө аж ахуйн бодлогын асуудлыг маш тодорхой тусгахыг хичээх хэрэгтэй. Монгол Улсад хөгжлийн бодлогын залгамж чанар байхгүй байна. Өнөөдөр хэчинээн сайхан зорилт тавиад сайн бодлого боловсруулахад хэрэгжүүлэх ажиллагаа, залгамж чанар нь алдагдчихаад байгаа. Аль нэг улстөрийн хүчин хөдөөгийн хөгжлийн асуудлаар хэт баруун тийшээ туйлширсан бодлого барьдаг, нөгөө нь хэтэрхий зүүн тийшээ туйлширсан бодлого барьдаг. Зөвхөн хөдөө аж ахуй ч биш, аль ч асуудлаар хоёр тийшээ зулгаасан байдлаас болоод хэчинээн сайн бодлого байлаа ч хэрэгжихгүй байна. Тийм учраас бодлогын залгамж чанарыг авч үзэх ёстой байх.

Өнөөдөр төрийн зүгээс, малчдын зүгээс ч бэлчээр, байгаль орчинд хандаж байгаа нь нэг л биш болсон байна. Хэдхэн хоногийн өмнө Мянган малчны зөвлөлгөөн гэсэн маш том арга хэмжээ боллоо. Харамсалтай нь тэр чуулганд оролцсон малчдын амнаас хөгжлийн тухай үг бараг унасангүй. Нөгөө л социализмын үеийн бэлэнчлэх сэтгэлгээгээр хандаж, бидэнд ийм ийм юм өгөөч гэсэн байдлаар ярьж байна. Бэлчээрийн мал аж ахуйн оршин тогтоно үндэс бол бэлчээр юм. Гэтэл бэлчээр асар их цөлжилтэд автагдаад байна. Мал бол хувийн өмч. Бэлчээр бол төрийн өмч, гэхдээ нийтээр ашиглаж байгаа өмч юм. Зах зээлийн үед нийтээр ашиглаж буй ямар ч юмыг хувийн өмчийн эзэн аль болох богино хугацаанд идэж дуусгах араншингаар хандахаас биш түүнийг хамгаалъя, сайжруулъя, удаан хугацаагаар тогтвортой ашиглая гэсэн сэтгэлгээ байдаггүй. Төрийн болон малчдын зүгээс бэлчээр, байгаль орчныг хамгаалах хандлагад эрс өөрчлөлт хийхгүйгээр хөгжлийн тухай ярихад хэцүү юм. Бэлчээрийг эзэмшүүлэх талаар энэ илтгэлд дурдсан байна. Эзэмшүүлнэ гэдгийг малчид өмчилнө гэж ойлгодог. Өмчлүүлэхгүй, харин эзэмшүүлнэ. Хуулийн үзэл баримтлалаар бэлчээрийг малчдын бүлэг, нөхөрлөлийн дунд нь, хоршоодод нь, фермерийн аж ахуйд нь эзэмшүүлье гэж байгаа. Нэг малчинд эсвэл нэг өрхөд эзэмшүүлж болохгүй. Өөрөөр хэлбэл, малчид дангаар амьдрахаасаа илүү хамтдаа амьдрах, орчин үеийн шинжлэх ухаан, технологийн дэвшлийн үед малчид хамтын нийгмийн амьдралд оролцох хэрэгтэй байна. Тийм чиглэл рүү түлхэц өгөх маягаар мал

аж ахуйн суурь асуудал болсон бэлчээрийн хандлагаа нэн даруй өөрчлөхгүй бол болохгүй юм.

Төрийн зохицуулалттай холбоотой асуудал байна. Дэлхийн өндөр хөгжилтэй оронд ч, буурай хөгжилтэй оронд ч хөдөө аж ахуйн төрийн зохицуулалт маш тодорхой юм байна. Жишээ нь, ХАА-н бүтээгдэхүүн, түүхий эдийн үнийн талаар ямар бодлого явуулах вэ, аль салбарт татаас өгөх вэ, татварын ямар бодлого баримтлах вэ, даатгалын ямар бодлого баримтлах вэ гэдэг нь маш тодорхой. Гэтэл манайд төрийн зохицуулалтын тодорхой бодлого байхгүй. Жишээ нь, татварын хуулиар ямааг хонин толгойд шилжүүлэх коэффициентийг 0.9 биш, тэмээний коэффициентээр шилжүүлчихвэл ямааны тоо аяндаа буураад ирнэ. Ямааны эзлэх хувь тухайн малчны нийт малын төдөн хувиас нь илүү байвал түүнд илүү татвар ногдуулж болно. Ингэж байгаль орчинтойгоо нийцсэн төрийн бодлоготой баймаар байна. Бид ноднин санал дэвшүүлээд УИХ-аас дэмжлэг авч чадаагүй. Энэ асуудал дээр цаашид анхаарах хэрэгтэй юм.

Эцэст нь хоёр асуулт тавья. Бэлчээрийн мал аж ахуй, тэр дундаа малчдын амьдралын нүүдлийн хэв маяг хэдий болтол явах вэ. Үүнийг 100 хувь устгах гэж хэлж байгаа юм биш. Гэхдээ зохих хэмжээний өөрчлөлт оруулахын тулд, малчдыг хөгжил рүү тэмүүлдэг болгоход түлхэц байх ёстой юу. Зуны хэдэн сар жаргачихаад өвөл маш хүнд байдалд орохоороо төрөөс баахан юм нэхээд суудаг сэтгэлгээнээс хэзээ гарах вэ. Гаргахын тулд ямар механизм хэрэгтэй вэ?

Малын тоог хязгаарлах ёстой гэж та илтгэлдээ хэллээ. Ямар механизм байж болох вэ?

**Ш.Гунгаадорж /Монгол Улсын Ерөнхий сайд асан, Шинжлэх Ухааны Академийн гишүүн, доктор, гавьяат агрономич/**

Бэлчээрийн мал аж ахуйн талаар түрүүн тодорхой санал хэлсэн. Харьцангуй суурин, хагас суурин амьдралын хэв загварын элементүүдийг нэвтрүүлье гэж. Жишээ нь, өвлийн хахир хатуу цагт харьцангуй суурин байдаг, зун нь тэндээ үлдэж үйлдвэрлэл эрхэлдэг байх юм уу. Ийм байдааар бэлчээрийн мал аж ахуй хэвээр байна. Гэхдээ ХХI зууны малчин хүн алин болгон хөл гарaa хөлдөөгөөд явах вэ дээ. Миний үеийн 1940-1950 оны сургуулиас гарсан хэсэг малчин 1990 он хүртэл явсан. Одоогийн хөдөлмөрийн баатар, аваргууд чинь манай мал аж ахуйг ХХ зуунд авч явсан гол хүч юм. Тэдний дараах үе одоо эхэлсэн. Шал өөр шаардлагаар өөр орчинд өсч торnisон малчид учраас жалгын нэг байж болохгүй. Энэ рүүгээ бодлогоо чиглүүлбэл яасан юм бэ.

Малын тоог хязгаарлана гэдэг бол арай өөр ойлголт юм. Ер нь тооны хойноос хөөцөлдөх бодлогыг барихгүй аль болох эрчимжүүлэх, ашиг шимиийг нэмэгдүүлэх чиглэл рүү л явъя. Жишээ нь, 1.2 кг гардаг арван хоньтой байх уу, 2 кг гардаг 5 хоньтой байх уу. Энэ бол ойлгомжтой асуудал. Малын тоог яг 30 саяд барина гэдэг хэцүү байх. Харьцангуй тооны хязгаар нь нэгдүгээр асуудал биш гэсэн санаа юм.

**Ч.Раднаа /УИХ-ын гишүүн/**

Хөдөөгийн хөгжил дотор хоёр зүйлийг нэмж яривал зүйтэй болов уу. Нэгдүгээрт, нутгийн

удирдлагын байгууллага буюу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн захиргааны байгууллага хоёрын эрх мэдлийг өргөжүүлэх, бие даан ажиллах чадварыг нэмэгдүүлэх асуудал бол манай орон нутгийн чухал асуудал юм. Саяхан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийг шинэчлэх асуудлыг бидний хэдэн гишүүн санаачилж УИХ-д оруулан батлуулсан. Энэ хуулиар орон нутагт ажиллаж, амьдарч буй иргэдийн эрх мэдлийг өргөжүүлж, орон нутгаа удирдах шийдвэр гаргахад нь оролцох эрх, нэгэнт гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх оролцоог нь нэмэгдүүлэх арга хэмжээг авч оруулсан байгаа.

Хоёрдугаарт, байгаль орчны асуудал байна. Байгаль орчин нь төв газарт байлгүй л яахав. Гэхдээ гол асуудал нь хөдөөд байгаа. Өөрөөр хэлбэл, өдөр тутам харж хамгаалах боломжтой, дэргэд нь байдаг малчид, тариаланчид, хөдөөгийн ард иргэдийн дэргэд байгаа юм. Тийм учраас байгаль орчныг хамгаалдаг тогтолцооны уламжлалыг эрс өөрчлөх шаардлагатай байна. Сая ойн тухай хуулийг шинэчиллээ. Та сая малчин бол зөвхөн малчин биш, малчин үйлдвэрлэгч байх ёстой гэж хэллээ. Түүнтэй санал нэг байна. Бас малчин ойчин байж болох юм. Тухайн нутгийнхаа ойг хардаг, хамгаалдаг, тордог, самар жимсийг нь ашигладаг, гишүүг нь түүгээд зарж болдог, тэрэг чаргаа хийдэг. Малааmallahaас гадна орон нутгийнхаа ойг хамгаалж орлогын нэмэгдэл эх үүсвэрийг бий болгох нөхцлийг бүрдүүлж байгаа юм. Тийм учраас байгаль орчны салбарын асуудлыг хөдөө рүү чиглэсэн бодлогын нэг хэсэг гэж үзэх нь зөв гэж бодож байна.

Малчид татваргүй байна гэдэг дээр нэг зүйл хэлмээр байна. Зөвхөн манайх бэлчээрийн мал аж ахуйтай орон биш гэдгийг та бүхэн мэнднэ. Бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг олон улс орон байна. Тэд хоёр төрлийн татвар төрдөө өгдөг юм билээ. Нэгдүгээрт, ашиг орлогын татвар, хоёрт, бэлчээр ашигласны төлбөрийг өгнө. 1000 малтай Раднаа гэдэг малчин ямар нэгэн орлого ашиг олж байгаа. Ноос, ноолуур, айраг, сүү, мах гээд. Орлого л олж байгаа бол орлогын татвар төлөх ёстой болно. Би 1000 малаа төрийн өмчийн газар дээр гишгүүлж, бэлчээр усыг нь ашиглаж байгаагийн хувьд бэлчээрийн төлбөрийг өгөх ёстой. Өнөөдөр манайд нийлүүлээд ганцхан татвар авч байгаа. Ашиг, орлогыг нь тооцоход хэцүү. Энэ жилд авсан айргийг нь гүүгээр нь үржүүлнэ гэхээр гүүгээ баригчий, ямаагаа самнаагүй, хонио саагаагүй, хяргаагүй гээд байдаг. Тиймээс бүгдийг нь нийлүүлж төвийн бүсэд хонин толгойд шилжүүлсэнээр 100 төгрөг, жаахан цаад бүсэд нь 75 төгрөг, бүр хязгаарын бүсэд нь 50 төгрөгөөр тооцон авч байгаа. Ердөө л энэ. Татвар бага байгаа нь үнэн. Түүний оронд төрөөс нэлээн их юм өгч байгаа шүү. Нэг хүүхдийн их, дээд сургуульд 4-5 жил үнэгүй суралцах, 10 жил хүүхдийг нь дотуур байранд үнэ төлбөргүй суулгах, бэлчээрийн усан хангамж, бэлчээр усжуулах, царцаа, үлийн цагаан оготнотой тэмцэх, дээр нь гоц халдварт өвчинөөс урьдчилсан сэргийлэх тарилга туулга, вакцины үнэ, үйлчилгээний хөлсийг төрөөс 100 хувь дааж байгаа. Паразитах өвчний эмийн үнийг дааж байгаа. Гоц халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх, тэр бүү хэл өвчин тусвал эмчилж эдгэрүүлэх бүх зардлыг тэр дааж байгаа. Мал нь гоц халдварт өвчинөөр

хорогдсон байвал малжуулах үүргийг төр хариуцаж байгаа. Малчдын өмнө их юм хариуцаж байгаа нь үнэн. Гэтэл малчид саяын зөвлөгөөнөөс их зүйлийг шаардаж байна лээ.

Бэлчээрийн эрх зүйн орчныг бүрдүүлэх нь малчдын төлөө л хийж байгаа. Энэ 34-35 сая бэлчээрийн малаа их удаан хугацаагаар маллаж амьдрах юм сан. Нэг өдөр хад мөргөж бэлчээргүй болоод сөнөж устгачихгүй юмсан гэдэг үүднээс хийж байгаа ажил юм.

Сая 1000 малчнаас 25 асуултаар санал авахад нэгдүгээрт, бэлчээрийн зохицуулалтыг төрөөс хийх ёстой, хоёрдугаарт, малын чанарын талаар төрийн бодлого хэрэгтэй, гуравдугаарт, малын хулгайтай тэмцэх талаар төрийн бодлого хэрэгтэй гэсэн байна. Энэ гурван чиглэлээр хууль санаачлаад явж байна. Зарим хуулийг шинэчлэх талаар ярьж байгаа.

**Ш.Гунгаадорж /Монгол Улсын Ерөнхий сайд асан, Шинжлэх Ухааны Академийн гишүүн, доктор, гавьяат агрономич/**  
Нэг илтгэлд бүгдийг оруулах боломжгүй. Үндсэн илтгэл дотор байгаль орчны асуудал орсон. Төрийн захиргааны асуудал нь орон нутгийн чухал асуудал мөн. Үүнтэй санал нэг байна.

**Ч.Авдай /УИХ-ын гишүүн/**  
Монголын нүүдэлчин малчид өөрсдөө ажлын байраа бий болгодгоороо онцлогтой. Малаа өсгөж хүүхдээ сурган ажиллуулдаг уламжлалтай. Гэхдээ нүүдэлчдэд хуримтлал байдаггүй. Олсон зүйлээ тэр дор нь үрчихдэг. Гайгүйхэн нь түүгээрээ хурдан морь, жороо

морь аваад байдаг. Харин сүүлийн жилүүдэд хашаа хороогоо гайгүй болгож, трактор, нарны төхөөрөмж, телевизортой болж байгаа.

Гурван жилийн өмнө Өвөр Монголын телевизээр хоёр малчны тухай үзүүлж байсан. Малчид нь өөр өөрийнхөө газраа заагаад хүрээгээр нь төмөр утас татчихсан байсан. Тэнд хоёр айл байна. Нэг нь 1000 гаруй малтай, жил бүр малынхаа зарим хэсгийг борлуулдаг. Мөн трактортой, цахилгаантай, гүний худагтай байгаа юм. Нөгөө малчин нь малаа өсгөсөөр байгаад 3000 болгочихсон. Зуд болсон чинь 1000 гаруй малтай айлын мал нь үхээгүй. Харин 3000 гаруй малтай айлын 2000 гаруй мал нь үхчихсэн байсан. Манай хөдөөд тийм л маягаар явж байгаа шүү дээ.

Цаг агаар хүндхэн байдаг нутгийн хүмүүс ажилсаг гэж илтгэгч ярилаа. Манай аймгийн цаад талын баяд, дөрвөдүүд их ажилсаг. Булган аймгийн Бүрэгхангай суманд Увс аймгийн Малчин sumaас ирсэн 100 гаруй айл байна. Зун нүүж ирээд намар нь өвөлжөөгөө тохижуулж бариад сайхан тухалчихсан байдаг. Булганы дарга нар нь намар ирсэн айл өвөлжөөгөө өөрсдөө барьчихаж байна гэж хэлэхээр тэндэхийн уугуул малчид нь ирэх жил барина даа гэдэг. Ирэх жил барих гэдэг нь худлаа. Өвөл цас их унаж хүйтэн болдог учраас баруун аймгийн бог мал нь хөлөөрөө цас цавчиж иддэг. Зүүн аймгаас ирсэн мал нь цасан доороос өвс хайгаад шургаад явчихдаг. Тэр үед нь малчид сайн ажиллахгүй бол болохгүй. Мал аж ахуйгаас гадна бололцоотой газруудад хүнсний ногоо тарих ажлыг шуурхай зохион

байгуулах хэрэгтэй. 2000 онд сонгуульд нэр дэвшиж Баруунтуруун суманд очиход 13-хан хүн ногоо тарьдаг байсан юм. Мал их цөөн, хүн олонгийн газар. Гэхдээ усалгааны системтэй. Яамнаас гүйж байгаад зургаан шуудай Канадын үрийг та нар ногоо тарь гэж аваачиж өгсөн. Гэтэл 2004 онд 260 гаруй өрх айл 450 гаруй тонн ногоо хураан авч байсан. 70 кг-ийн гурилын шуудайнд төмс, манжин, лууван, байцаагаа холиод нэг шуудайг нь нэг төлгөнөөс малчидтай наймаалцаж байсан. Малчид нэг төлгийг 4-5 хоног иднэ. Гэтэл шуудай ногоог сар хэрэглэнэ биз дээ. Хэн хэнийхээ хэрэгцээг хангах тийм менежментийг л зааж өгмөөр байгаа юм.

1960-1970 оны үед Солонгост авгайчууд нь жаахан наймаа арилжаа хийж хэдэн төгрөг олдог. Орой очихоор нөхөр нь мөнгийг булааж аваад архи учихдаг. Манайхны одоогийн үе шиг иймэрхүү байж л дээ. Цэргийн эргэлтээр гарч ирсэн өрөнхийлөгч нь архи уудаг тэр хүмүүсийг хүчээр дайчлан хүлэмж байгуулж ажиллуулсан. Хүлэмж дээрээ өнжин хонон ажиллаад тэдэнд архи уух зав огт гараагүй. Цалин авна. Намар болохоор идэх уух юмтай болно. Цаг агаар түвэгтэй болж байгаа энэ үед манайх хүлэмжийн аж ахуйг хөгжүүлмээр байгаа юм. Хөдөөд ч, хотод ч адил.

Хятадаас ирж байгаа хүнсний ногоо баталгаа их муутай. Эрээнд манай хүмүүст өөрсдийн иддэг ногоо, монголчуудад зардаг ногоо хоёр өөр байдаг гэж хэлж байсан. Монголчуудад зардаг ногоо нь 2-3 дахин хямд байгаа юм. Гаднаас ирж буй тусlamжийн цагаан будаа, улаан буудай бол хэдэн жил хадгалсан эд л

байгаа шүү дээ. Цаашид удаан хадгалахад түвэгтэй болчихсон учраас л ирж байгаа. Тиймээс өөрийнхөө хэрэгцээтэй зүйлээ өөрсдөө хангах чиглэлд ажиллах хэрэгтэй.

Увс аймгийн Тариалан сумын хотон айл бүр 2-3 га газартай. Тэд өөрсдөө усална, зэрлэгээ зулгаана. Нэг га-гаас 50-иад центнер үр тариа авдаг. Олон жилийн өмнө улсын тариа авч байсан норм нь 9-11 центнер байсан. Одоо бол 6-7 центнер байгаа. Түүнийгээ борлуулж боловсруулаад гурил хийж байна. Ингэж хүмүүсийг ажилд сургах нь зүйтэй. 1000 малчны зөвлөлгөөн дээр тэдний ярьж байгаагаас үзвэл мал нь ахиухан болоод ирэхээр малаа өөрөө маллахгүй, 2-3 хүн авч ажиллуулаад өөрөө УАЗ 469 машинаар чоно хөөгөөд давхидаг гэнэ. Зөвлөлгөөнд ирсэн малчдын ихэнх нь тиймэрхүү. Тэгхээр ажилсаг чанарыг сургахад нь анхаармаар юм уу.

Эрх зүйн орчинг сайжруулах дээр бид ажиллаж байна. Лизингийн хууль ноднин батлагдсан. ХАА-н техникийн лизингийн хууль гэж тусдаа хууль байхгүй. Лизингийн өрөнхий хуулийн хүрээндээ л явна. Хуулиа үзэх хэрэгтэй. Хуучин тракторыг гадагшaa гаргаж байна гэлээ. Төмөр гаргахгүй гэж хорьчилоод байхад яагаад гараад байдаг юм бол. Үүнийг анхаарч үзье.

#### **Д.Содном /Монгол Улсын Ерөнхий сайд асан, гавьяат эдийн засагч, профессор/**

Хөдөөгийн хөгжлийн бүх асуудлыг ярина гэвэл дийлж хязгаарт нь гарахгүй байх. Энэ их том асуудлыг бүхлээр нь ярих биш, төр засгийн зүгээс юуг нь анхаарах вэ гэдэг дээр голлож яривал цэгтэй болно гэж бодож байна.

Төрөөс дараахь таван асуудал дээр анхаарлаа төвлөрүүлж шийдэх хэрэгтэй юм.

1. Мал аж ахуй, газар тариалан эрхэлж буй хүмүүс бүтээгдэхүүнээ хэрхэн борлуулах,
2. ХАА-н бүтээгдэхүүнийг боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүдийг байгуулах,
3. Үндсэн хуульд мал төр, төрийн хамгаалалтад байна гэж заасан байгаа. Малыг төрийн хамгаалалтад байлгана гэдэг юу гэсэн үг юм бэ?
4. Бэлчээрийг мал аж ахуй эрхлэгчдэд эзэмшүүлэх хуулийг яаралтай гаргах,
5. Татварыг боловсронгуй болгох асуудал дээр УИХ-ын гишүүд анхаарал төвлөрүүлж шийдвэл болчих юм биш үү. Технологи болон малын тоо нь төрийн шийдвэр гэхгүйгээр аяндаа зохицуулагдчих асуудал байх.

Мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүнийг борлуулах зах зээлийг ойртуулж өгөх талаар саналаа хэлье. Би нэлэнх хэдэн жилийн өмнө уншиж байсан юм. 1932 оны үед Америкт эдийн засаг хямралд ороод ажилгүйдэл их, нийгмийн байдал нь маш хүнд үе байсан. Тухайн үед Рузвелт өрөнхийлөгч болоод олон арга хэмжээ авсны нэг нь хөдөө аж ахуй руу чиглэсэн байна. Энэ арга хэмжээ бол улсаас улаан буудайг худалдаж авах тухай хууль байсан юм. Хэрвээ Америкт үйлдвэрлэхгүй бол дэлхийн зах зээл дээрээс улаан буудайг ямар үнээр худалдаж авах вэ гээд тэр үнээр нь улсаас улаан буудайг худалдаж авч эхэлсэн. Тэгээд 1941 онд хоёрдугаар дайн эхлэхэд Америк өөрийн хоёр жилийн хэрэгцээгээ хангах хэмжээний буудайны нөөцтэй болсон гэнэ лээ. Хэрвээ цэвэр орчинд хийсэн гурилтай больё гэж байгаа бол бид ийм худалдан авах арга хэмжээг зохион

байгуулж хуулиа гаргачих хэрэгтэй. Асуудал аяндаа шийдэгдэнэ. Айл бүр өөртөө жижигхэн систем хийгээд ганц хоёр га-гаар нь буудайгаа тариад байхад хэрэгцээгээ хангачихна.

Малын хувьд ч мөн адил. Таваарт өгөх малыг худалдаж авдаг болмоор байна. Худалдаа бэлтгэлийн хуучин системийг боловсронгуй болгож сэргээмээр байна. Ноос ноолуурыг ч бас худалдаж авдаг болмоор байна. Үүнийг худалдаж авчихаад улсаас жижиг, дунд үйлдвэрүүдийг бий болгож, зарим хэсгийг нь экспортод гарган борлуулаад байж чадна. Малчид, тариаланчид ченжүүдийн аманд битгий орчилоосой билээ. Татварын асуудлыг шийдэхэд энэ их амар болчихно. Одоо малын толгойд нь ногдуулах байдлаар татварын бодлого явж байгаа. Орлого, ашгаас татвар авна гэдэг нь шударга биш. Мал борлосон ч юм уу, үгүй ч юм уу, таваарлаг ч юм уу, үгүй ч юм уу. Хэрвээ улсаас гол бүтээгдэхүүнээ ингэж худалдаж авдаг болчихвол экспорт болон үйлдвэрлэлд ашиглах асуудлаа зохистой шийдэж чадна. Татварын асуудлаа ч зохистойгоор шийдэж чадна.

Бэлчээрийг өмчлөх тухай асуудал биш юм. Эзэмшүүлэх л асуудал. Өвөр Монголд үүнийг шийдэж байгаа сургтай. Зарим зүйлийг нь би уншиж байсан. Тэдний туршлагыг манайхан анхаарсан байсан. Тэнд анхаармаар юм ч байна, болгоомжилмоор юм ч байна. Тэр хуулийг нь авч үзээд өөрт тохирсон аятайхан хувилбарыг гарган ярилцаж байгаад түргэхэн шийдэх юмсан. Тэгэхгүй бол бэлчээр сүйрч дууслаа шүү. Ялангуяа хот суурин газрын ойролцоо бэлчээр талхлагдаж дууслаа. Зах хязгаарын малчид нүүж ирээд байгаа учраас

тэнд үлдсэн бэлчээр л гайгүй байх. Одоо ашиглая гэвэл тийшээ эзэмшүүлээд өгчих.

### **Б.Батбуян /Бэлчээрийн мал аж ахуйн судалгааны төв/**

Мал аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулна гэж байна. Тухайлбал, төвийн бүс байна. Хойд талаараа Сэлэнгэ, Төв аймаг гээд эрчимжсэн мал аж ахуй хөгжих нөхцөл илүү байхад урд талын Өмнөговь, Дундговь нь уламжилсан бэлчээрийн мал аж ахуй хөгжих илүү боломжтой харагдаж байгаа юм. Ийм ялгаатай газрыг нэг бүсэд оруулж хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлого гэж дэвшүүлэх нь өрөөсгөл санагдаж байна. Малчид бүтээгдэхүүнээ борлуулж зах зээлдээ ойртох, нийгмийн асуудлаа шийдвэрлэе гэсэн хүсэл эрмэлзэлтэй байгаа учраас аймгуудын төвийг тойрсон хот орчмын аж ахуйг түлхүү дэмжиж бодлого дэвшүүлбэл яласан юм бэ. Та үүнийг юу гэж бодож байна вэ?

Малчдын дунд чинээлэг, дунд, ядуу малчин ч бий. Ийм учраас тэдний хүсэл сонирхол нь өөр өөр. Түүнд нь тохируулж амжиргааны түвшингээр нь ялгасан, тэдний хэрэгцээг хангахад чиглэсэн хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлого дэвшүүлж болохгүй юм уу. Жишээ нь, татварын бодлого, хөрөнгө оруулалт дээр. Хөрөнгө оруулалт гэхээр ядуу малчин мөнгө авч чадахгүй. Барьцаагаа ч өгч чадахгүй байгаа. Гэтэл дундаж амжиргааны хүн өөрийн гэсэн хөрөнгөтэй байгаа. Бага зэрэг зээл авахад түлхээд л хөгжинө шүү дээ. Америк болон бусад оронд нийгмийн давхаргын өөрийгөө хөгжүүлэх чадвартай

хэсэг буюу дундчуудыг түлхэх бодлогыг төрөөс баримталдаг шүү дээ. Ингэж түлхэж өгвөл тэд өсөөд л ядуу малчдаа татаж ажлаар хангаж нийгмийн бүтцэд зохистой тогтолцоог үүсгэдэг. Гэтэл манайд хүн болгон ядуу гэж байгаад тусlamж авахыг боддог. Иймэрхүү зөрчилдөөнийг засч залруулахад чиглэсэн санаа дэвшүүлж болох уу.

### **Ш.Гунгаадорж /Монгол Улсын Ерөнхий сайд асан, Шинжлэх Ухааны Академийн гишүүн, доктор, гавьяат агрономич/**

Таван бүс гэдэг нь байгалийн баялаг, хөдөө аж ахуй зэрэг олон үзүүлэлтийг харгалzan үзээд аль нь эдийн засгийн хувьд, нийгмийн хувьд ашигтай хослол байх вэ гэж харсан бүтэц юм. Жишээ нь,.gov нь хангайтай яаж харьцаж болох, яаж хамтран ажиллах вэ гэдгийг олон талаас нь харгалзсан бүс байгаа юм. Гэхдээ нэг бүс нь зөвхөн эрчимжсэн мал аж ахуй, нөгөө нь дан бэлчээрийн мал аж ахуй гэдэг утгаараа биш юм. Жишээ нь, төвийн бүсэд Сэлэнгэ аймаг байгалийн цаг уурын хувьд бололцоотой учраас эрчимжсэн мал аж ахуй эрхэлж болно, үйлдвэржсэн мал аж ахуйч эрхэлж болно. Төрөөс үзүүлэх ямар хэлбэрийн дэмжлэг байж болох, өмчийн эзэн малчны зүгээс бүтээгдэхүүнээ борлуулах орлогоосоо хуримтлал бий болгох гэх зэргээр харилцан уялдаатай бодлого хэрэгтэй. Төрийн зүгээс өрөөсгөл бодлого баримтлах учир шалтгаан байхгүй. Өнөөдөр малчин хүн Говь-Алтайд бүтээгдэхүүнээ борлуулах ямар ч бололцоо байхгүй. Тэгээд сүү, цагаан идээ нь тэр чигээрээ л өнгөрч байна. Тийм учраас жижиг, дунд үйлдвэрлэлийн сүлжээ буюу хуучнаар бол худалдаа бэлтгэлийн анги хэлбэрийн бүтэц

байж болох юм. Гэхдээ зах зээлийн нөхцөлд тохирсон сүлжээг бий болгох нь чухал.

### **Б.Дорж /ХААИС-ийн багш/**

Уур амьсалаас шалтгаалж газар тариалан эрхлэхэд хэцүү болж байгаа тухай ойлголт газар авч байна. Тийм биш юм. Тариа ургахад дулаан, ус хоёр адилхан л хэрэгтэй. Яах гэж ийм олон хүлэмж барьж байгаа юм. Хүйтнээс хамгаалахын тулд л шүү дээ. Говийн аймгуудад, Алтайн цаад говьд хүлэмж бариад байгаа амтат гуя, тарвас зэргийг арвай буудай тарьдаг шиг хөрс рүү шигтгэн суулгаж, усалж байгаад ургацаа авч болно. Тийм учраас газар тариаланд хүнд үе ирээд байгаа юм биш. Харин төвийн хэсэгт усалгааны асуудлыг ярих нь зөв байх.

Газар тариаланд уламжлал байхгүй гэж үзэж болохгүй. Тариа тарих талаар хамгийн сайн мэддэг хүмүүс Увс аймгийн Тариалан сумын хотонгууд юм. Ховдын торгуудууд эрт дээр үеэс тариа тарьж байсан уламжлалтай, нутаг усандaa нэрд гарсан хүмүүс их байдаг юм билээ. 1212 онд Чингис хаан тариа тариулах асуудлаар зарлиг гаргаж байсан түүхтэй. Түүнээс хойш тасралтгүй явж ирсэн нь тодорхой хэмжээний уламжлалыг бий болгосон гэж бодож байна.

Монгол улс өдий хүртэл оршин байгаагийн цаад учир нь мал, малчин хоёр байх аа. Малчид бүгд юм нэхээд суугаад байгаа хүмүүс биш. Тэдний дотор учир ойлгодог, мал маллах эрдэм ухаанд төгс боловсорсон хүмүүс олон бий. Тэдний туршлагыг залуучууддаа эзэмшүүлэх талаар тодорхой санааг оруулах хэрэгтэй юм. Энэ талаар орон нутгийн засаг

захиргааны байгууллагууд ихээхэн үүрэг гүйцэтгэх байх. Малчин гэдэг бол их нарийн мэргэжил юм. Бэлчээр, цаг агаар, нутаг ус, хөрс гээд олон юмыг хамарсан, малынхаа үржлийн талаар нарийн мэдлэгтэй, мал таних арга ухаантай байх гээд. Үүнийгээ уламжлуулсаар өдий хүрч иржээ. Малчны залуу халааг бэлтгэх талаар бодох хэрэгтэй юм.

Илтгэлийн явцад хүнсний хэрэглээний нэг хүснэгт цухалзаад өнгөрлөө. Миний харснаар улсын дунджаар өрхийн хэрэглээний 60 хувь нь гурил, гурилан бүтээгдэхүүн байна гэж байна. Үнэхээр тийм бол газар тариалангийн асуудлыг нэлээн ярих хэрэгтэй юм.

Арван жилийн хугацаанд төмс, хүнсний ногоо, үр тарианы асуудал багасна гэсэн. Энэ бол биелэгдэх байх. Хэмжээ нь нэмэгдчих байх. Гэхдээ энэ нь одоо байгаа хүндээ тооцоогүй, хүнээ өсөхийг нь бодож тооцсон тоо болов уу гэж ойлгож байна.

### **В.Удвал /Удирдлагын академийн багш/**

Хөдөөгийн хөгжлийн бодлогын асуудал дотор нийгмийн асуудлыг шийдэх нь хамгийн чухал гэж үзэж байна. Хоцрогдож байгаа зүйл бол хөдөөгийн хүмүүсийн үйлчилгээ юм. Жишээ нь, 600 км-ийн цаана нүүгээд явж байгаа малчин хүнд үйлчилгээгээ яаж хүргэх юм бэ гэдэг асуудлыг бодох ёстой.

Малтай холбоотой төрийн бодлого байх шаардлагатай. Сүүлийн хоёр сарын хугацаанд турван аймгийн 11 sumaар явлаа. Бодлогоор зохицуулах зүйл их харагдаж байна. МАА-н арга ажиллагаатай холбоотой зүйлүүд байна.

Тухайлбал, бэлчээр, мал эмнэлгийн үйлчилгээ, даатгалын үйлчилгээ гээд.

Газар тариалангийн том аж ахуйнууд унаачихсан байдалтай байгаа. Газар тариаланг усалгаанаас шалтгаалдаг гэдэг. Хашаандаа хэдхэн га газарт тариа ногоо тариад л сайн байна, аж ахуйгаа хөгжүүлж байна гэж яриад байдаг. Гэтэл энэ жижиг аж ахуй нь цаашдын хөгжилд хүргэх нь үү, үгүй юу гэдэг нь бүрхэг л байна.

#### **Жадамбаа /”Бэлчээрийн тогтвортой менежмент” төслийн зөвлөх/**

Монгол оронд хамгийн чухал асуудал бол хөдөө аж ахуй, түүний дотор мал аж ахуй. Мал аж ахуйд бэлчээр их чухал үүрэгтэй. Өнөөдөр мал аж ахуй эрхэлж буй үйл ажиллагааг зах зээлд шилжээгүй байна гэж би боддог. Зах зээлээс хоцорч байгаа. Бэлчээр ашиглалт нь дураараа, малын эм тан бүгд үнэ төлбөргүй. Бүх юм чөлөөтэй. Татвар гэж бараг байхгүй. Орлого нь хоёр талаас бүрдэнэ. Өөрөөсөө авна, улсаас их хэмжээний орлого бүрддэг. Малын эм, усан хангамж болон бусад зүйл гээд. Малчид хуучны өгөөч гэсэн сэтгэлгээгээр явж байна. Ингэж зах зээлээс хоцроох нь маш буруу юм. Мал аж ахуй эрхлэхтэй холбоотойгоор фермерийн аж ахуйн тухай хууль гаргана гэж ярьж байна. Энэ бол мал аж ахуй эрхлэх тухай хууль гэж байх ёстой. Түүн дотроо бүгд багтана. Хэсэг бүлгээр нь, тусад нь авч үзээд байхаар энэ нь асуудал биш болоод байна аа. Мал аж ахуй эрхлэх хууль байхгүй учраас ийм байдалд хүрээд байгаа юм.

Малын өсөлтийг хязгаарладаг ганц зүйл бол бэлчээр юм. Гэтэл малын өсөлт хязгааргүй байж болохгүй шүү дээ. Бэлчээр өөрийн багтаамжтай

учраас түүгээр хязгаарлах ёстой. Нэг газар очоод шавчихдаг. Бэлчээрийг зөв ашиглах, бэлчээрийг эзэнтэй болгох, бэлчээрийн эзэмшлийн асуудлыг зөв шийдэх хэрэгтэй. Эзэмшүүлэх болон гэрээгээр ашиглах зэрэг ашиглалтын олон хэлбэрийг сонгох хэрэгтэй.

Малчин өрх цөөн. 230 мянган малтай өрх бий гэж ярьдаг. Түүний 178 мянга нь малчин өрх. Жинхэнэ мал аж ахуй эрхэлдэг, нэлээн томхон мал аж ахуйтай өрх бол 60-70 мянгаас хэтрэхгүй. Цаана нь малтай мөртлөө тавиул болгоод тавьчихдаг баахан өрх бий. Энэ бүгдийг мал аж ахуй эрхлэх хуулиар зохицуулж өгөх нь зөв . Ганцхан асуулт асууя. 500-700 мянган га орхигдсон тариалангийн талбай бий гэж ярьдаг. Үүнийг яах вэ?

#### **Ж.Санжмятав /УБ хотын Хүнс хөдөө аж ахуйн газрын мал аж ахуйн хэлтсийн дарга/**

Малын эмч, зоотехникч хоёр зогсч байж мал аж ахуй хөгждөг юм. Төр засгаас гаргасан тогтоол, хөтөлбөр, сайд, дарга нарын илтгэл, хүмүүсийн ярианд малын үржил селекцийг сайжруулах гэсэн өгүүлбэр орж байгаа боловч түүнийг хийж гүйцэтгэдэг мэргэжилтний тухай огт дурдагдаггүй. Өнөөдөр Монгол улсад мал эмнэлэг гэж маш хүчтэй хөгжсэн том арми бий. Улаанбаатар хотын жишээгээр ярихад төв агентлаг мал эмнэлэгтэй, түүнийг тойрсон 18 мал эмнэлэг дүүргүүдэд ажиллаж байна.

Малын эрүүл мэндийн талаар цогц арга хэмжээг бид авч чадаж байгаа. Харин үржил селекц, малын чанар сайжруулах ажил үнэхээр хоцрогдолтой байна. Яг үнэнийг хэлэхэд

мэргэжлийн зоотехникч гэхэд надаас өөр хүн байхгүй. Малын чанар сайжруулах талаар гаргасан төр засгийн тогтоол шийдвэр нь толгойноос өндөр үүрэг даалгаврыг оногдуулж байдаг. Гэтэл улсын хэмжээгээр ажиллаж байгаа зоотехникч маш цөөн, малын эмч өдий төдийхөн. Малын чанарыг сайжруулахад зоотехникч онцгой үүрэг гүйцэтгэнэ. Тийм учраас мэргэжилтний талаар энэ илтгэлд тусгаж, үржил селекцийн ажлыг мэргэжлийн үүднээс явуулахгүй бол болохгүй ээ. Ардын селекц гэдгийг дээр үеийн хашир малчид хийж байсан. Яг үнэнийг хэлэхэд одоогийн энэ залууст мэдэж байгаа юм байхгүй. Хөдөө тийм л байгаа. Үүнийг онцгой анхаарах хэрэгтэй байна.

Төв суурин газар, аймгийн төв, Эрдэнэт, Дархан, Улаанбаатар хот орчимд хүссэн ч, хүсээгүй ч эрчимжсэн мал аж ахуй бий болно. Хот орчмыг тойроод улаан халцгай болгочихсон байгаа. Хүн амын хүнсний хэрэгцээ зайлшгүй учраас эрчимжүүлэх л ёстой. Тийм учраас бэлчээрийн газрыг эзэмшүүлэх нь зүйтэй. Сумаасаа 50-60 км-ийн цаанаа тэмээн тэргээ хөтлөөд, трактороо унаад өвсний соргог, усны тунгалагийг даган нүүгээд явдаг айлын тухайд бэлчээрийн газрыг эзэмшүүлэх, өмчлүүлэх тухай асуудал байж таараахгүй ээ. Энэ бүтэхгүй асуудал.

Фермерийн эрх зүйн байдлын тухай хууль хоёр жилийн өмнө УИХ-д өргөн баригдсан гэж би сонссон. Одоо хүртэл гардаггүй. Урдуур нь дайраад байдаг юм байлгүй. Жадамбаа гуайтай санал нэг байна. Мал аж ахуй эрхлэх тухай хууль гэдэгт нийтлэг байдлаар оруулж өгвөл зүйтэй байх.

Ямааны өсөлтийг хязгаарлана гэдэгтэй санал нийлэхгүй байна. Энэ бол зах зээлийнхээ хуулиар явна. Дэлхийн болоод дотоодын зах зээл дээр ноолуурын үнэ өндөрт хүрсэн учраас ард түмэн ямаагаа өсгөж чадаж л байгаа. Зах зээлийн хуулиараа ноолуурын үнэ буураад ирвэл малчид маань ямаагаа цөөрүүлэхээ мэднэ.

**Ш.Гунгаадорж /Монгол Улсын Ерөнхий сайд асан, Шинжлэх Ухааны Академийн гишүүн, доктор, гавьяат агрономич/**

Газар тариалангийн салбар унасаар байгаад одоо ашиглаж буй талбай нь бараг үгүй болчихсон байгаа. Эргэлтийн талбай нь 200-300 мянган га байна. 1 сая 100 мянган га эргэлтийн талбайтай хэвийн явж байсан нь аяндаа л алга болсон байхгүй ю. Одоо газар тариалан тэлж хөгжөөд ирэхээр нөгөө талбайнууд эргэж ашиглалтад орох ёстай. 200 гаруй мянган га газар элэгдэл эвдрэлд орж, цэлжчихсөн байна. Энэ нь өөрөө сэргэх замаар явах байх. Таван жилийн дараанаас хаягдсан талбайн байгалийн ургамал нь нөхөн сэргээд явдаг юм байна лээ. Эхний жилдээ лууль шарилж ургаж байгаад хоёр, гуравдахъ жилээс багассаар багассаар хэвэндээ очно. Энэ бол жаахан хэсэг нь. Газар тариалангаа сэргээн, улс орны үндэсний аюулгүй байдлыг хамгаалж будаа тариагаа идэх ёстой юм бол талбайгаа ашиглах л ёстой.

Энэ баримт бичигт та бүгдийн санал нэмэгдээд төр засгийн удирдлагуудад очих юм. Бид ч бас зүгээр суугаад байхгүй. Араас нь хөөцөлдөнө. Энэ илтгэл хөдөө аж ахуйг хөгжүүлэх бодлогод хувь нэмэр болох байх гэж бодож байна.

## ГАРЧИГ

<b>1. Хөдөөгийн хөгжил .....</b>	<b>1</b>
1. 1. Хөдөөгийн нийгмийн асуудал .....	3
1.2. Жижиг дунд үйлдвэрийг хөдөөд хөгжүүлэх бодлого .....	7
<b>2. Монгол орны мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх зарим асуудал .....</b>	<b>10</b>
2.1. МАА-н салбарын өнөөгийн байдал.....	10
2.2. Малын тооны өсөлт, сургийн нөхөн үйлдвэрлэл .....	10
2.3. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого, чиглэл.....	12
2.4 Мал аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх бодлого .....	13
2.5. Мал аж ахуй эрхлэх хэлбэр, эрчимжүүлэх чиглэл .....	17
2.6. Бэлчээр ашиглалтын бодлого .....	18
2.7. Малыг байгалийн эрсдлээс хамгаалах бодлого .....	19
2.8. Дүгнэлт, санал .....	20
<b>3. Монгол улсын газар тариалангийн салбарын хөгжлийн асуудал .....</b>	<b>23</b>
1. Тариалалтын өнөөгийн байдал .....	23
2. Газар тариалан сэргээн хөгжүүлэхэд зайлшгүй анхаарах зарим асуудал .....	25
3. Тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх арга зам.....	26
<b>Хэлэлцүүлгийн тэмдэглэл .....</b>	<b>31</b>